



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРОО



МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН САЛБАР 2017



Тээврийн салбарын статистикийн тайлантай холбоотой мэдээлэл ба санал хүсэлт байвал доорх хаяг болон вэб сайтад хандана уу.

Хаяг: Засгийн газрын III байр,
Бага тойруу -44, Улаанбаатар -11
Монгол Улс

Вэб хаяг: www.nso.mn, www.1212.mn

Мэдээллээр үйлчлэх төв

Онлайн: <http://web.nso.mn/onlinechat/index.php>

Утас: 1900-1212

Холбогдох мэргэжилтэн

Утас: 51-261563 /О.Мандахзориг/

И-мэйл: mandakhzorig@nso.mn

Зөвлөмж

Энэхүү тайланд агуулагдсан бүх мэдээлэл Үндэсний статистикийн хороо, Иргэний нисэхийн ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн санд байдаг бөгөөд хувь хүн, албан байгууллага ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүйгээр бүрэн ашиглаж болно.

Мэдээллийн эх үүсвэр

Энэхүү тайланд ашигласан өгөгдлүүд нь хэвлэгдэх үед гарах хамгийн сүүлийн үеийн тоон үзүүлэлтүүд болно. Статистикийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдийг авто зам, төмөр зам, агаарын тээвэр, дотоодын усан тээврийн үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас цуглуулсан болно.

Танилцуулгыг боловсруулсан: Эдийн засгийн статистикийн газрын тээврийн салбар хариуцсан шинжээч О.Мандахзориг

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

ТҮҮХЭН ТОВЧОО

УДИРТГАЛ

БҮЛЭГ НЭГ: Монгол Улсын тээврийн салбарын дэд	
бүтцийн өнөөгийн байдал, цар хүрээ	1
Хөрөнгө оруулалт	1
Төсөл хөтөлбөр	3
Монгол Улсын авто замын сүлжээ	4
Тээврийн хэрэгслийн бүртгэл	11
Техникийн хяналтын үзлэг	14
Автомашинны импорт	20
Агаарын тээвэр	21
Төмөр замын тээвэр	21

БҮЛЭГ ХОЁР: Тээврийн салбарын эдийн засгийн үндсэн үзүүлэлт	22
Аж ахуйн нэгж, байгууллага	22
Ажиллагчид	23
Орлого бүрдэлт	24

БҮЛЭГ ГУРАВ: Зорчигч тээврийн үндсэн үзүүлэлт	26
Агаарын тээвэр	26
Төмөр замын тээвэр	28
Авто замын тээвэр	29
Усан замын тээвэр	30

БҮЛЭГ ДӨРӨВ: Ачаа тээврийн үндсэн үзүүлэлт	32
Агаарын тээвэр	33
Төмөр замын тээвэр	34
Авто замын тээвэр	36

БҮЛЭГ ТАВ: Зам тээврийн осол, зөрчлийн үндсэн үзүүлэлт	38
Зам тээврийн ослын шинжтэй дуудлага	38
Бүртгэгдсэн зам тээврийн осол	38
Зам тээврийн ослын ангилал	39
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээрийн хэрэгслийн ашиглалт журмын эсрэг гэмт хэрэг	39
Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, боловсрол	40
Зам тээврийн ослын улмаас нас барсан, гэмтсэн хүн	41
Зам тээврийн ослын шалтгаан	42
Хүүхэд өртсөн зам тээврийн осол	45

Товчилсон үгийн жагсаалт

ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс

ТҮҮХЭН ТОВЧОО

Монгол Улс 1925 оноос ачаа тээж эхэлснээр ачаа тээврийн анхны баримт бичгийг бий болгож тээвэрлэсэн ачааны нэр, хэмжээ, тээврийн зайг бүртгэн тодорхойлох болсон байна.

Монгол Улсад орчин үеийн тээврийн салбаруудаас хамгийн анх үүсэж хөгжсөн нь авто тээвэр юм. Улаанбаатар хотоос Хэнтий аймаг хоорондох морин өртөөг 1924 онд татан буулгаж, Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар 6 машинтай шуудан буудлыг байгуулж, улмаар 1925 онд 12 автомашинтай “Монгол тээх нэвтрүүлэх” газар болгон өргөтгөж, Улаанбаатар, Алтан булагийн хооронд бараа таваар, зорчигч тээвэрлэх болсон байна.

“Монгол тээх нэвтрүүлэх” газрыг 1929 онд өргөтгөн “Монголтранс” гэдэг авто тээврийн аж ахуйг байгуулжээ.

Тээврийн Яамыг 1940 онд байгуулж, авто тээврийн аж ахуйг удирдан зохион байгуулах ажлыг төвлөрүүлж, авто машины ашиглалтыг сайжруулж, бүтээлийг нь нэмэгдүүлэх, авто тээврийг төлөвлөгөөтэй удирдаж, бүртгэл тооцоог сайжруулах арга хэмжээ авч байжээ.

Авто машин ашиглалтын нэгдсэн тайлангийн маягтыг Тээврийн яамнаас 1942 онд боловсруулан авто баазуудад мөрдүүлсэн байна.

Манай улсад 1938 онд анх Улаанбаатар-Налайхын хооронд нарийн төмөр зам, 1939 онд Чойбалсан-Соловьевскийн хооронд өргөн төмөр зам, 1949 онд ЗХУ-н

Наушкаас Улаанбаатар хот хүртэл, 1956 онд Улаанбаатар-Замын-Үүдийн төмөр замыг ашиглалтад оруулснаар БНМАУ-д төмөр замын тээврийн сүлжээ бий болов.

1945 оноос Москва-Улаанбаатарын хооронд онгоцоор зорчигч тээвэрлэх болж, аймгуудад эмнэлгийн түргэн тусламж үзүүлэхэд онгоц хэрэглэх болсноор Монголын иргэний агаарын тээврийн эх үүсвэр тавигджээ. Монголын иргэний агаарын тээврийн газар 1956 онд байгуулагдав.

1970-аад оноос эхлэн тээврийн салбарын мэдээ тайланг төвлөрүүлэх, нэг хэвийн болгох, автомашин, чиргүүл, өөрөө явагч механизмын үзлэг тооллогыг жил бүр явуулж, түүний материалыг тооцоолон бодох электрон машинаар боловсруулах, тээврийн сар, улирал, жилийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг гаргах, тээврийн байгууллагын үйл ажиллагаанд судалгаа хийх, үйлдвэрлэлийн үр ашиг, техник, эдийн засгийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг улам боловсронгуй болгох зэрэг ажлуудыг гүйцэтгэж иржээ.

Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр бүх төрлийн тээврийн хэрэгслийн ихэнх нь хувийн өмч болж, авто тээврийн үйлчилгээ бараг бүхэлдээ хувийн хэвшилд очсон байна. Үүнтэй уялдан уг салбарын статистикийн мэдээллийн маягт, аргачлалыг шинэчлэн боловсруулах шаардлага гарч 2008 онд тээврийн статистикийг тооцох аргачлалыг боловсруулан мөрдөж байна.

Удиртгал


Тээврийн салбар нь өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшилтай манай улсын хувьд эдийн засагт чухал ач холбогдолтой салбарын нэг юм.

Тээврийн салбарын статистикийн жилийн тайланд улс орны тээврийн систем, салбарын хөрөнгө оруулалт, ажиллах хүч, эдийн засагт оруулж буй хувь нэмэр мөн түүнчлэн тээврийн осол, зөрчлийн талаар тайлбарлах болно.

Манай улсад авто зам, төмөр зам, агаар, усан замын үндсэн 4 төрлийн тээврийн салбаруудад 2929 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээрийн 50.1 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Өнгөрсөн 2017 онд Монгол Улсын хэмжээнд сайжруулсан авто замын урт 10.6 мянган километр, 536.4 мянган автомашин улсын үзлэгт хамрагдаж, ойролцоогоор 1815 километр урт төмөр зам, улсын болон хувийн хэрэглээний 23 онгоцны буудал, гэрчилгээтэй 16 агаарын хөлөг иргэдэд үйлчилсэн байна.

Салбарын хэмжээнд 2017 онд нийт 1422.3 тэрбум төгрөгийн орлого бүрдэж, давхардсан тоогоор 215.7 сая хүнд үйлчилгээ үзүүлж, иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагын 54.0 сая тонн ачааг тээвэрлэсэн байна.



Үндэсний Статистикийн Хорооны Эрхэм зорилго

Улс төрийн аливаа нөлөөлөлд
автахгүйгээр эдийн засаг,
нийгэм, хүн ам зүйн талаархи
шинжлэх ухааны арга зүйгээр
тооцсон, статистикийн үнэн
бодит мэдээлэл, судалгаагаар
төр, засаг, иргэн байгууллагад
адил тэгш үйлчлэхэд оршино.

Монгол Улсын тээврийн салбарын дэд бүтцийн өнөөгийн байдал, цар хүрээ

Манай Улс бүх төрлийн тээврийн хэрэгслээр 2017 онд давхардсан тоогоор 215.7 сая Монгол Улсын иргэн, 542.7 мянган гадаадын иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Хувийн болон нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон бүх иргэд энэ салбарын нэг хэсэг болж байдаг.

Тээвэрлэлт нь ажилдаа зорчих, бараа үйлчилгээ авах болон үзүүлэх, гэр бүл, найз нөхөдтэйгөө уулзах, алс холын газруудаар аялах боломжийг олгодог. Энэ нь эдийн засгийг дэмжиж, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, ажиллагчидтай холбоотой маш олон бизнесийг холбож байна.

Энэхүү бүлэгт тээврийн салбарын хөрөнгө оруулалт, дэд бүтэц, авто тээврийн хэрэгслийн бүртгэл, авто техникийн үзлэг, оношилгооны мэдээллийг хүргэх болно.

1.1 Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр

Тээврийн салбарт 2017 онд гадаадын болон дотоодын эх үүсвэрээс 142.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийжээ. Энэ нь нийт хөрөнгө оруулалтын 1.4 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн жилээс 0.9 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Нийт хөрөнгө оруулалтын дүнд эзлэх хувь

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017*
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3.6	3.3	5.4	3.2	5.9	1.6	2.3	1.4
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.6	0.5	0.7	0.8	1.5	2.7	1.2	1.0
Уул уурхай олборлолт	45.8	61.9	50.0	46.1	15.2	26.6	16.6	43.3
Боловсруулах үйлдвэр	1.9	1.1	1.5	3.5	6.9	6.8	6.7	1.5
Барилга	6.8	11.8	9.7	12.2	18.2	15.2	20.6	10.0
Бусад	41.3	21.4	32.7	34.2	52.3	47.1	52.7	42.9


Монгол Улсын тээврийн сүлжээний сайжруулалтад зориулсан улсын төсвийн хөрөнгө оруулалт нийтдээ 77.2 тэрбум төгрөг, үүнээс авто замын сүлжээнд 41.0 тэрбум, гүүр болон их засварын ажилд 19.5 тэрбум, тээврийн салбарт 16.7 тэрбум төгрөгийг тус тус төсөвлөсөн байна. Авто замын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын 80.1 хувийг гадаадын зээл, үлдсэн 19.9 хувийн дотоодын хөрөнгийн эх үүсвэр эзэлж байна ¹.

Хөрөнгө оруулалтыг технологийн бүтэц талаас нь авч үзвэл 2017 онд 1 их наяд 331.6 тэрбум төгрөгийг тээврийн хэрэгслийн хөрөнгө оруулалт оруулсан ба энэ нь өнгөрсөн оноос өссөн бол, сүүлийн 10 жилийн дунджаас дээгүүр үзүүлэлт юм.

¹ Эх үүсвэр: <http://www.iltod.gov.mn/?p=3980>

Тээврийн хэрэгслээр хийгдсэн хөрөнгө оруулалтын дийлэнх нь уул уурхай, газар тариалан, барилгын салбарт өндөр хувийг эзэлж байна.

Зураг 1. Тээврийн хэрэгслийн хөрөнгө оруулалт, дүнд эзлэх хувиар



1.2 Тээврийн салбарт хэрэгжиж буй томоохон төсөл, хөтөлбөр

1.2.1 Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын иргэний нисэхийн салбарт томоохон өөрчлөлт гарч байна. Одоогийн “Чингис Хаан” Олон улсын нисэх буудлын үйлчилгээнд тулгарч буй хүндрэлүүдийг арилгах, нисэхийн аюулгүй ажиллагааны хангалтыг дээшлүүлэх, агаарын тээвэрлэлтийг тогтворжуулах, Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигийн хөндийд “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл”-ийг Япон улсын Засгийн газрын 65.6 тэрбум иений хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж 2018 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.



1.2.2. Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл

Монгол Улсын Засгийн Газар энэхүү төслийг АХБ-тай хамтран санхүүжүүлж байгаа бөгөөд нийт төсөвт өртгийн 60 гаруй хувь буюу 45 сая ам.долларын хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийг АХБ-аас шийдвэрлүүлсэн байна. Төсөл нь хэрэгжиж логистикийн төв баригдсанаар Монгол Улсын импорт, экспорт, дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдэж эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой юм.

Уг төсөл нь Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хэрэгжиж байгаа бөгөөд нийт 128 га талбайг хамрах бөгөөд чингэлгийн, хүнд даацын, агуулахын гэсэн 3 бүстэй байхаар төлөвлөгдсөн. Мөн 50 тн даацтай 2 гүүрэн кран, механизмын засварын төв, өргөн болон нарийн царигийн ачилт буулгалтын 11.5 км орчим төмөр зам, логистикийн төв руу орох гарах төмөр замтай 2 түвшинд огтлолцох хүнд даацын тээврийн хэрэгсэл явах боломжтой гүүрэн байгууламж, 1.6 км авто зам тус тус барихаар төлөвлөгдсөн.

2017 оны эцэс хүртэл Логистикийн төвийн барилга угсралтын ажил тодорхой үе шаттай хэрэгжиж ирсэн бөгөөд одоогийн байдлаар логистикийн төвийн үйл ажиллагаанд 11.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 3,6 км цэвэр усны шугамын ажил, Төмөр замтай 2 түвшинд огтлолцох гүүрэн байгууламж, 1.6 км авто замын барилга угсралтын ажил, 4.15 км гадна холбоо интернетийн шилэн кабель суурилуулах ажил, Гадна цахилгаан хангамжийн 110кВ ЦДАШ, дэд станцын өргөтгөл, дэд станцын барилга угсралтын ажил зэрэг ажлуудыг дотоодын гүйцэтгэгч 9 компани хийж гүйцэтгээд байгаа юм.

1.3 Монгол Улсын авто замын сүлжээ


Улс орны хөгжлийн үндсэн тулгуур нь яах аргагүй зам юм. Зам нь хүн төрөлхтний соёл иргэншил, техник технологийг холбож, худалдаа, ажил эрхлэлт, аялал жуулчлал, эд баялгийн хуваарилалт, илүү нэгдсэн ертөнц зэрэг бүхий л төрлийн сайн зүйлсийг бий болгодог. Авто замын нийгэмд оруулж буй хувь нэмрийг зөвхөн санхүүгийн талаас нь дангаар харах биш өв соёлтойгоо танилцах, уламжлалт ёс заншлаа дэлгэрүүлэх зэрэг ач холбогдлыг нь тооцох хэрэгтэй.

Аливаа улсын эдийн засгийн нөхцөл байдал сайжрах тусам авто замын салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байдаг бөгөөд бүтээн байгуулсан авто зам нь эргээд эдийн засагтаа хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндэс болж байдаг. Манай улс 1992 оноос 2012 оны хооронд 2.1 мянган км авто замыг улсын хэмжээнд барьсан бол 2012 оноос 2016 оны хооронд 3.3 мянган километр, 2017 онд 377 километр авто замыг ашиглалтад оруулжээ.


Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 2017 оны байдлаар 113.2 мянган километр. Үүнээс хатуу хучилттай нь 10.6 мянган километр, хучлагагүй буюу ердийн болон сайжруулсан хөрсөн зам 102.6 мянган километр байгаа бөгөөд авто замын хучилтын төрлийг нийт авто замын сүлжээнд эзлэх хувиар нь авч үзвэл асфальтбетон зам 9055.1 километр буюу 8.0 хувь, хайрган зам 1215.9 километр буюу 1.1 хувь, хөнгөвчилсөн зам 205.2 километр буюу 0.2 хувь, цементбетон зам 81.7 километр буюу 0.1 хувь байгаа бол 101.9 мянган километр буюу 90.7 хувийг ердийн болон сайжруулсан хөрсөн зам эзэлж байна.

Монгол Улсын авто замын нийт сүлжээнд олон улсын болон улсын чанартай зам 15231.3 км, орон нутгийн чанартай зам 95959.4 км, тусгай зориулалтын буюу уул уурхайн зориулалттай зам 1126.2 км, нийслэлийн авто зам 870 км зам эзэлж байна. Олон улсын болон улсын чанартай авто замын 48.3 хувийг ердийн хөрсөн зам, 41.9 хувийг асфальтбетон зам, 6.1 хувийг хайрган зам, 2.09 хувийг сайжруулсан хөрсөн зам, 0.2 хувийг цементбетон зам эзэлж байгаа бол орон нутгийн чанартай замын 98.6 хувийг ердийн хөрсөн зам, 0.8 хувийг асфальтбетон зам, 0.6 хувийг хайрган болон сайжруулсан хөрсөн зам тус тус эзэлж байна.

Зураг 2. Сайжруулсан замын урт, км




Сайжруулсан авто замд хатуу хучилттай, хайрган хучилттай, сайжруулсан хөрсөн замыг хамруулдаг бөгөөд улсын хэмжээнд 2017 оны байдлаар сайжруулсан авто замын урт 2005 оныхоос 77.9 хувь, 2010 оныхоос 62.0 хувь, өмнөх оныхоос 7.7 хувиар өсөж, 10905.5 км-т хүрсэн байна. Үүний 9055.1 км буюу 83.0 хувь нь хатуу хучилттай зам, 1215.9 км буюу 11.1 хувь нь хайрган хучилттай зам, 634.5 км буюу 5.8 хувь нь сайжруулсан хөрсөн зам байгаа бөгөөд өмнөх оныхоос хатуу хучилттай зам 21.4 хувь буюу 1598.5 км-ээр нэмэгдсэн бол хайрган хучилттай зам 480 км буюу 28.3 хувь, сайжруулсан хөрсөн зам 338.1 км буюу 34.8 хувиар буурсан байна.



Зураг 3. Авто замын сүлжээнд хатуу хучилттай замын эзлэх хэмжээ, км

- Олон улсын болон улсын чанартай зам: 7552.9
- Орон нутгийн чанартай зам: 1008.2
- Нийслэлийн зам: 870.6
- Тусгай зориулалтын зам: 1126.2



Зураг 4. Авто замын сүлжээнд хучлагагүй буюу ердийн болон сайжруулсан замын эзлэх хэмжээ, км

Олон улсын болон улсын чанартай зам: 7678.4
Орон нутгийн чанартай зам: 94951.2

1.3.1 Олон улсын чанартай авто зам

Олон улс, улсын чанартай авто замуудад ихэвчлэн хот хооронд болон хотоос хилийн боомт чиглэлийн замууд ордог ба 2017 онд ЗТХЯ-аас шинэчлэн тогтоосон Олон улс, улсын чанартай авто замын нийт урт 15231.3 километр бөгөөд хатуу хучилттай зам 49.6 хувь, хучлагагүй зам 50.4 хувийг тус тус эзэлж байна. Хучлагатай замд асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсөн, хайрган зам ордог бол хучлагагүй замд сайжруулсан хөрсөн, ердийн хөрсөн зам багтдаг байна. Доорх хүснэгтэд олон улс, улсын чанартай авто замын мэдээллийг замын байршлаар үзүүлэв.

Хүснэгт 2. Олон улс, улсын чанартай авто замын урт, замын байршлаар

Авто замын чиглэлийн нэр	Нийт замын урт	Хучлагатай	Хучлагагүй
		Километр	
Улсын дүн	15 231.3	7 552.9	7 678.4
Улаанбаатар-Замын-Үүд боомт	661.9	661.3	0.6
Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад-Гашуунсухайт боомт	876.5	818.2	58.3
Улаанбаатар-Арвайхээр-Баянхонгор-Алтай-Ховд-Өлгий-Цагааннуур	1 781.1	1 378.9	402.2
Улаанбаатар-Дархан-Сүхбаатар-Алтанбулаг боомт	345.2	345.2	-
Улаанбаатар-Өндөрхаан-Чойбалсан-Сүмбэр боомт	1 050.2	671.3	378.9
Элсэнтасархай-Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг-Тэс-Арцсуурь боомт	852.2	574.8	277.4
Өлгий-Увсын Өлгий	213.1	2.4	210.7

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Авто замын чиглэлийн нэр	Нийт замын урт	Хучлагатай	
		Хучлагагүй	Хучлагагүй
Километр			
Хархорин-Хужирт-Арвайхээр	90.3	55.3	35.0
Дашинчилэн-Булган-Мөрөн	475.1	370.8	104.3
Дархан-Эрдэнэт-Булган	223.2	223.2	-
Ханх боомт-Хатгал-Мөрөн-Улиастай-Алтай-Бургастай боомт	1 200.2	262.5	937.7
Бууцагаан-Цагаанхайрхан	238.6	-	238.6
Хутаг-Өндөр-Тэшиг-Бага илэнх боомт	134.9	35.0	99.9
Манхан сум-Булган боомт	355.3	355.3	-
Өлгий-Даян боомт	184.4	8.8	175.6
Улаангом-Үүрэгнуур-Цагааннуур	181.8	17.9	163.9
Ховд-Улаангом-Боршоо боомт	346.7	197.4	149.3
Нөмрөг-Сонгино-Наранбулаг-Улаангом	358.2	288.3	69.9
Өндөрхаан-Норовлин-Баян-Уул	272.7	110.7	162.0
Өндөрхаан-Баруун-Урт-Бичигт боомт	468.1	245.6	222.5
Чойбалсан-Баян-Уул-Ульхан боомт	240.7	240.7	-
Баруун-урт-Чойбалсан-Эрэнцав боомт	418.4	18	400.4
Энгэршанд-Хавирга боомт	74.9	-	74.9
Налайх-Тэрэлж	30.4	30.4	-
Зуунмод-Налайх	28.2	28.2	-

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Авто замын чиглэлийн нэр	Нийт замын урт	Хүснэгт 2-ын үргэлжлэл	
		Хучлагатай Километр	Хучлагагүй
Баянхонгор-Шаргалжуут	54.2	-	54.2
Лүн-Дашинчилэн-Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир	330.9	194.8	136.1
Хархорин-Хөшөөцайдам-Өгийнуур	88.9	55.3	33.6
Арвайхээр-Гучин-ус-Шивээхүрэн боомт	454.6	55.0	399.6
Хатгал-Жанхай-Тойлогт	34.1	31.9	2.2
Улиастай-Сархайрхан-Мянгад	438.9	49.5	389.4
Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр боомт	107.7	107.7	-
Даланзадгад-Шивээхүрэн боомт	306.2	88.3	217.9
Арвайхээр-Мандалговь-Сайншанд	626.5	5.1	621.4
Сайншанд-Баруун-Урт	303.4	0.6	302.8
Чойр-Өндөрхаан	225	-	225
Чойр-Говь-Угтаал-Мандалговь	184.3	-	184.3
Сайншанд-Даланзадгад	393.6	-	393.6
Сайншанд-Ханги боомт	328.3	24.5	303.8
Мөрөн-Тариат	252.4	-	252.4

Дээрх хүснэгтээс харахад ихэнх аймгууд Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбогдсон бол аймаг хооронд болон аймгийн төвүүд хилийн боомтуудтай хатуу хучилттай замаар бүрэн холбогдож чадаагүй байна. Монгол Улсын хамгийн урт улсын чанартай авто зам бол Улаанбаатар хотоос Арвайхээр-Баянхонгор-Алтай-Ховд-Өлгий хотоор дамжин Цагааннуур хүртэл 1781.1 км бөгөөд нийт замын 77.4 хувь нь хатуу хучилттай, үлдсэн 22.6 хувь нь ердийн болон сайжруулсан хөрсөн зам байна.

1.3.2 Орон нутгийн чанартай авто зам

Орон нутгийн чанартай авто замуудад ихэвчлэн аймгийн төвөөс сум, сумаас сумын хооронд замууд ордог ба 2017 онд ЗТХЯ-аас шинэчлэн тогтоосон орон нутгийн чанартай авто замын нийт урт 95959.5 километр бөгөөд хатуу хучилттай зам 1.1 хувь, хучлагагүй зам 98.9 хувийг тус тус эзэлж байна. Доорх хүснэгтэд орон нутгийн чанартай авто замын мэдээллийг аймаг тус бүрээр нь харуулав.


Хүснэгт 3. Орон нутгийн чанартай авто замын нийт урт, аймгаар

Аймгийн нэрс	Нийт замын урт	Хучлагатай	
		Хучлагагүй	Хучлагагүй
Километр			
Улсын дүн	95959.5	1008.3	94951.2
Архангай	3543.3	15.2	3528.1
Баян-Өлгий	3583.7	34.6	3549.1
Баянхонгор	4888.6	14.0	4874.6
Булган	4242.6	61.8	4180.8
Говь-Алтай	6993.3	22.0	6971.3
Говьсүмбэр	364.5	8.0	356.5
Дархан-Уул	247.6	35.2	212.4
Дорноговь	8858.8	15.7	8843.1
Дорнод	3367.6	32.1	3335.5
Дундговь	4944.4	12.5	4931.9
Завхан	3908.3	8.3	3900.0
Орхон	140.1	104.6	35.5
Өвөрхангай	5228.2	27.0	5201.2
Өмнөговь	5236	46.0	5190.0
Сүхбаатар	4015.3	46.4	3968.9
Сэлэнгэ	3020.8	268.8	2752.0
Төв	9067.5	129.4	8938.1
Увс	9086.2	32.8	9053.4
Ховд	6892.1	52.4	6839.7
Хөвсгөл	3659.6	27	3632.6
Хэнтий	4671	14.5	4656.5

Орон нутгийн чанартай замын хамгийн урт нь Увс, Төв аймагт байгаа бол Дархан-Уул, Орхон аймгуудад хамгийн бага ногдож байна. Орон нутгийн чанартай хамгийн урт хучилттай замтай Сэлэнгэ, Төв, Орхон аймгууд байгаа бол эсрэгээрээ Завхан, Говьсүмбэр, Архангай аймгууд байна.

1.3.3 Авто замын гүүр

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар 707 ширхэг буюу 34171.8 метр урт төмөр бетон, ган гүүр болон модон гүүр бүртгэгдсэн бөгөөд улсын чанартай авто замд 348 ширхэг, 15136.8 метр, орон нутгийн чанартай авто замд 272 ширхэг, 14143.8 метр, нийслэлийн авто замд 67 ширхэг, 3956.6 метр, тусгай зориулалтын авто замд 20 ширхэг буюу 934.6 метрийн урт гүүр байна.



Нийт гүүрийг хийцийн төрлөөр нь задлан авч үзвэл төмөр бетон гүүр 439 ширхэг буюу 23940.8 метр, модон гүүр 256 ширхэг буюу 7973.7 метр, Ган гүүр 12 ширхэг буюу 2257.3 метрийн урттай гүүр бүртгэгдсэн байна.

Олон улсын болон улсын чанартай авто замд төмөр бетон гүүр 289 ширхэг буюу 13766.8 метр, модон гүүр 58 ширхэг буюу 1086 метр, Ган гүүр 1 ширхэг буюу 284 метр ногдож байгаа бол орон нутгийн чанартай авто замд төмөр бетон гүүр 68 ширхэг буюу 6086.8 метр, модон гүүр 195 ширхэг буюу 6603.7 метр, ган гүүр 9 ширхэг буюу 1453.3 метр гүүр байна. Дээрхээс харахад, нийт төмөр бетон гүүрний 52 хувь нь олон улс болон улсын чанартай авто замын гүүрэнд харьяалагдаж байгаа бол нийт модон гүүрний 76.2 хувь нь орон нутгийн чанартай авто замд бүртгэгдсэн байна.

Хүснэгт 4. Монгол Улсын авто замын гүүрний тоо, хийцийн төрлөөр

Замын төрөл	Нийт	Ган гүүр	Төмөр бетон гүүр	Модон гүүр
Олон улс, улсын чанартай замд	348	1	289	58
Орон нутгийн чанартай замд	272	9	68	195
Нийслэлийн авто замд	67	2	64	1
Тусгай зориулалтын авто замд	20	-	18	2

Нийслэл Улаанбаатар хотод төмөр бетон гүүр 64 ширхэг буюу 3230.6 метр, гангүүр 2 ширхэг буюу 520 метр, модон гүүр 1 ширхэг буюу 206.0 метрийн урттай гүүр бүртгэгдсэн байна.

1.3.4 Орон нутгийн чанартай авто замын гүүр

Өнгөрсөн онд орон нутгийн чанартай авто замын гүүр 272 ширхэг буюу нийт 14143.8 метр урттайгаар бүртгэгдсэн байна. Үүнээс хамгийн олон гүүртэй аймаг Баян-Өлгий 42 ширхэг

буюу 1634.0 метр бол гүүрнүүдийнхээ уртын нийлбэрээр Хөвсгөл аймаг 2039.1 метр урттай гүүртэй байна. Харин хамгийн олон төмөр бетон гүүртэй Сэлэнгэ аймаг 16 ширхэг буюу 1239 метр урттай бол модон гүүрнийхээ тоогоор Баян-Өлгий аймаг 38 ширхэг буюу 1106.0 метр урт гүүртэйгээр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 5. Орон нутгийн чанартай авто замын гүүрний тоо, бүтээцийн төрлөөр

Аймгуудын нэрс	Үүнээс:							
	Нийт гүүр		Төмөр бетон		Ган төмөр		Модон	
	Тоо	Урт метр	Тоо	Урт метр	Тоо	Урт метр	Тоо	Урт метр
Улсын дүн	272	14143.8	68	6087	9	1453.3	195	6603.7
Архангай	21	1090.6	3	319.6	1	36	17	735
Баян-Өлгий	42	1634	4	528	-	-	38	1106
Баянхонгор	14	418.7	1	12	-	-	13	406.7
Булган	18	1109.4	8	324.4	4	720	6	65
Говь-Алтай	1	10	-	-	-	-	1	10
Говьсүмбэр	-	-	-	-	-	-	-	-
Дархан-Уул	5	237	5	237	-	-	-	-
Дорноговь	2	37.8	2	38	-	-	-	-
Дорнод	11	820.8	-	-	-	-	11	820.8
Дундговь	-	-	-	-	-	-	-	-
Завхан	28	946.9	1	144.9	0	0	27	802
Орхон	3	96	3	96	-	-	-	-
Өвөрхангай	9	310	2	36	1	7	6	267
Өмнөговь	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	1	15	1	15	-	-	-	-
Сэлэнгэ	21	1430.5	16	1239	1	150	4	41.5
Төв	29	1072	4	487	-	-	25	585
Увс	13	856	6	742	-	-	7	114
Ховд	8	334.2	3	220.2	-	-	5	114
Хөвсгөл	26	2039.1	5	908.9	1	326.5	20	803.7
Хэнтий	20	1685.8	4	739	1	213.8	15	733

Эх үүсвэр: Зам, тээврийн хөгжлийн яам


1.4 Тээврийн хэрэгслийн бүртгэл

Дэлхийн хүн амын тоо ойрын 25 жилд 9.2 тэрбумд хүрэх бөгөөд Хятад, Энэтхэг зэрэг хөгжиж буй орнуудын зах зээлийн бүс нутгуудад ДНБ өсөх нь автомашины хэрэглээг нэмэгдүүлж 2040 он гэхэд дэлхийн хэмжээнд 2 тэрбум автомашинтай болох тооцоолол гарсан гэж 2016 оны “Дэлхийн Эдийн Засгийн Форумд” танилцуулагдсан байна.

1929 онд Монгол Улсын хэмжээнд 20 автомашин замын хөдөлгөөнд оролцож байсан тэр үеэс өнөөг хүртэл 87 жилийг бид ардаа үджээ. Монгол Улсад 2017 онд бүртгэлтэй тээврийн


тээврийн хэрэгслийн тоо 900.1 мянга, автомашины тоо 815.0 мянга болж өнгөрсөн оноос тээврийн хэрэгслийн тоо 6.9 хувь, автомашины тоо 6.4 хувиар өссөн байна. Тээврийн хэрэгсэл гэдэгт ачааны болон суудлын автомашин, мотоцикл, чиргүүл, тусгай зориулалтын, автобус, механизм болон бусад өөрөө явагчийг хамруулах бол автомашин гэдэгт тээврийн хэрэгслээс мотоцикл, чиргүүл, механизмыг хасаж ойлгоно.

Зураг 6. Бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, автомашины тоо



Тээврийн хэрэгслийн сүүлийн 10 жилийн дундаж өсөлтийг авч үзвэл, жилд 17.1 хувь, автомашин 18.5 хувиар өссөн бол харин энэ хугацаанд хамгийн өндөр өсөлттэй жил нь 2012 он байсан бөгөөд тээврийн хэрэгсэл 58.7 хувь, автомашин 61.4 хувиар өсөж байжээ. Тээврийн хэрэгсэл болон автомашины сүүлийн 3 жилийн хувьд 6.0-7.0 хувийн тогтмол өсөлттэй байна. 2017 онд нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 56.9 хувь, автомашины 59.0 хувь нь Улаанбаатар хотод байна. Нийслэл хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийг дүүргээр салган авч үзвэл, Баянзүрх дүүрэг 22.9 хувь, Баянгол дүүрэг 18.4 хувь, Сонгинохайрхан дүүрэг 18.3 хувь, Сүхбаатар дүүрэг 14.7 хувь, Чингэлтэй дүүрэг 11.4 хувь, Хан-Уул дүүрэг 11.2 хувь, Налайх дүүрэг 1.6 хувь, Багануур дүүрэг 1.3 хувь, Багахангай дүүрэг 0.2 хувийг эзэлж байна. Харин аймгуудын хэмжээнд авч үзэхэд, Өмнөговь аймаг 3.7 хувиар тэргүүлж байгаа бол Орхон, Дархан-Уул, Өвөрхангай аймгууд удаалж, харин Говьсүмбэр аймаг 0.4 хувийг эзэлж хамгийн бага тээврийн хэрэгсэлтэй байна.

Зураг 7. Бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, автомашин, хувиар, аймаг нийслэлээр



Эх үүсвэр: ЦЕГ, Замын цагдаагийн алба

1.4.1 Тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа

2017 оны байдлаар Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийг ашиглалтын /насжилт/ байдлаар авч үзвэл 0-3 жил ашиглагдаж буй автомашин 28722 буюу 3.5 хувь, 4-6 жил болсон автомашин 67650 буюу 8.3 хувь, 7-9 жил 98002 буюу 12.0 хувь, 10 ба түүнээс дээш жил ашиглагдаж буй автомашины тоо 620635 буюу 76.2 хувийг эзэлж байна. Үйлдвэрлэгдсэнээс хойш 0-3 жил ашиглагдаж буй автомашин 2012 онд нийт автомашины 10.0 хувь, 2013 онд 6.4 хувь, 2014 онд 4.1 хувь, 2015 онд 2.7 хувь, 2016 онд 2.2 хувийг эзэлж байсан бол 2017 онд 1.3 пунктээр өсөж 3.5 хувь болж шинэ автомашин, тээврийн хэрэгслийн ашиглалт өссөн бол мөн 10 ба түүнээс дээш жил ашиглаж буй тээврийн хэрэгсэл 2.0 хувиар өссөн байна.



1.4.2 Тээврийн хэрэгслийн төрөл

2017 онд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн үзүүлэлтээс харахад суудлын автомашин 586821 буюу 65.2 хувь, ачааны автомашин 175648 буюу 20.2 хувь, мотоцикл 48192 буюу 5.4 хувь, автобус /нийтийн тээвэр/ 6864 буюу 0.8 хувь, тусгай зориулалтын 15096 буюу 1.7 хувь, чиргүүл 25591 буюу 2.8 хувь, механизм 11335 буюу 1.3 хувь, бусад төрлийн тээврийн хэрэгсэл 2.7 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Тээврийн хэрэгслийн өсөлт, бууралт, төрлөөр

Төрөл	2016		2017	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Суудлын	547 299	65.0	586 821	65.2
Ачааны	175 648	20.9	182 181	20.2
Мотоцикл	42 752	5.1	48 192	5.4
Чиргүүл	22 169	2.6	25 591	2.8
Тусгай	15 245	1.8	15 096	1.7
Автобус	6 823	0.8	6 864	0.8
Механизм	10 612	1.3	11 335	1.3
Бусад	20 989	2.5	24 047	2.7
Нийт	841 537	100.0	900 127	100.0


1.4.3 Автомашины жолооны хүрдний байрлал

Монгол Улсад бүртгэлтэй автомашины жолооны хүрд 404803 буюу 49.7 хувь нь зүүн талдаа, 410206 буюу 50.3 хувь нь баруун талдаа байрлалтай байна. Нийслэлд жолооны хүрд буруу буюу баруун талдаа байрлалтай 255756 автомашин хөдөлгөөнд оролцож байгаа нь нийслэлд бүртгэлтэй автомашины 55.7 хувийг эзэлж байна.

1.5 Техникийн хяналтын үзлэг

Монгол Улсад бүртгэлтэй нийт автомашины 59.6 хувь нь 2017 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан бөгөөд үзлэгт хамрагдаагүй автомашинууд нь ашиглалтаас гарсан ч улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хасалт хийлгээгүй шалтгаантай байна. Төвлөрсөн, төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт эдийн засгийн нийгэмд шилжиж байсан 1990 онд 43.8 мянган автомашин улсын үзлэгт хамрагдаж, мянган хүнд ногдох автомашины тоо 21 байсан бол 2017 онд 536.4 мянган автомашин болж 171 автомашин мянган хүнд ногдож байна. Авто тээврийн хяналтын үзлэгийг жил бүр улсын хэмжээнд 29 үйлчилгээний цэгт тогтмол хийдэг бөгөөд улсын хэмжээнд 2017 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашин тоо өнгөрсөн оноос 32.2 мянга буюу 7.5 хувиар өссөн байна. Үзлэгт хамрагдсан автомашины тоо 2000 оноос даруй 6.0 дахин, 2005 оноос 4.0 дахин, 2010 оноос 2.0 дахин, 2015 оноос 11.3 хувиар өссөн байна.


Зураг 9. Үзлэгт хамрагдсан автомашины тоо



Сүүлийн үед авто замын бүтээн байгуулалт, шинэчлэлтийг дагаад хөдөө, орон нутгийн иргэдийн дунд автомашины хэрэглээ тасралтгүй өссөөр байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашиныг бүсээр нь авч үзвэл, Төвийн бүс өнгөрсөн оноос 6.2 мянга буюу 11.5 хувиар өсөж 60.4 мянга, Хангайн бүс 2.5 мянга буюу 4.8 хувиар өсөж 53.6 мянга, Баруун бүс 2.3 мянга буюу 6.0 хувиар өсөж 40.6 мянга, Зүүн бүс 87 автомашин буюу 0.5 хувиар өсөж 15.9 мянган автомашин үзлэгт хамрагдсан байна. Хэдийгээр бүсийн дүн өсөлттэй гарч байгаа ч Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дархан-Уул, Дундговь, Төв, Сүхбаатар, Хэнтий зэрэг аймгуудын үзлэгт хамрагдсан автомашины тоо өнгөрөгч оноос буурсан байна. Харин Улаанбаатар хотын хувьд 2017 онд 365.8 мянган автомашин үзлэгт хамрагдаж өнгөрсөн оноос 26.2 мянга буюу 7.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2017 онд Монгол Улсын 885.6 мянган өрхийн 29.3 хувь нь суудлын автомашин, 6.7 хувь нь ачааны автомашин, 11.7 хувь нь мотоцикл эзэмшиж байна. Автомашинтай өрхийг хот, хөдөөгөөр нь задлан харвал, хотын өрхийн 33.4 хувь, хөдөө, орон нутгийн 20.7 хувь нь суудлын автомашинтай байгаа бол хөдөө, орон нутгийн нийт өрхийн 33.0 хувь, хотын өрхийн 1.3 хувь нь мотоциклтой байна.


Зураг 10. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машин, аймаг, нийслэлээр



Эх үүсвэр: Авто тээврийн үндэсний төв

Сүүлийн жилүүдэд автомашины тоо хурдацтайгаар нэмэгдэж, 100 хүнд ногдох болон 100 км²-д ногдох автомашины тоо нэмэгдсээр байна. 100 хүнд ногдох автомашины тоогоор Улаанбаатар 26.1 ширхэг автомашин ногдож байгаа бол Төвийн бүс 12.1, Баруун бүс 10.2, Хангайн бүс 9.1, Зүүн бүс 7.4 ширхэг автомашин ногдож байна. Мөн түүнчлэн авто машины тооны өсөлт нь нэг км² нутаг дэвсгэрт ногдох автомашины тоог нэмэгдүүлж байна. Монгол Улсын нийт хүн амын 46.0 хувийг өөртөө шингээж байгаа Улаанбаатар хотод 2017 оны байдлаар 100 км² нутаг дэвсгэрт ногдох авто машины тоо 7783, Хангайн бүсэд 14, Төвийн бүсэд 15, Баруун бүсэд 10, Зүүн бүсэд 6 болсон байна.

Зураг 11. 100 км² нутаг дэвсгэрт ногдох авто машины тоо, бүс нутгаар



1.5.1 Үзлэгт хамрагдсан автомашины төрөл


Улсын хэмжээнд техникийн хяналтын үзлэгээр 388.5 мянган суудлын, 120.7 мянган ачааны, 18.6 мянган автобус, 8.6 мянган тусгай зориулалтын автомашин хамрагдаж өмнөх оноос суудлын авто машин 7.7 хувь, ачааны автомашин 8.4 хувь, тусгай зориулалтын автомашин 4.3 хувиар өсөж, харин автобус 1.9 хувиар буурчээ. (Хавсралт 1)

Хүснэгт 7. Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо, төрлөөр

Төрөл	2000	2005	2011	2014	2015	2016	2017
Бүгд	81 693	131 184	312 542	437 677	482 049	499 152	536 399
Суудлын	44 051	87 792	208 514	303 724	343 288	360 513	388 448
Ачааны	24 671	27 435	75 090	96 581	110 024	111 431	120 751
Автобус	8 548	11 067	22 547	20 650	20 744	18 912	18 550
Тусгай зориулалт	4 423	4 890	6 391	16 722	7 993	8 296	8 650

Өнгөрөгч онд нийт үзлэгт хамрагдсан суудлын автомашины 72.6 хувь буюу 282.2 мянга, ачааны автомашины 56.0 хувь буюу 67.7 мянга, автобусны 53.5 хувь буюу 9.9 мянга, тусгай зориулалтын автомашины 69.5 хувь буюу 6.0 мянга нь Улаанбаатар хотод ногдож байна. Орон нутгийн хувьд Орхон, Баян-Өлгий, Өмнөговь аймгуудад хамгийн их суудлын автомашин үзлэгт хамрагдсан бол Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад ачааны автомашин ихээр хамрагдсан байна.


Зураг 12. Үзлэгт хамрагдсан автомашин дүнд эзлэх хувиар, төрлөөр, аймгаар



Дэлхийн нийт улсуудын 69.0 орчим хувь нь автомашины зүүн гар талын хүрдний дүрмийг баримталдаг байна. Үүнд: Америкийн Нэгдсэн Улс, Латин америк, Европын ихэнх улсууд багтдаг бол үлдсэн 31.0 хувь нь буюу хуучнаар Их Британийн колонид багтаж байсан

улсууд баруун гарын хүрдний дүрмийг баримталдаг байна. Манай улсын хувьд хэдийгээр зүүн гар талын хүрдний дүрмийг баримталдаг ч, үзлэгт хамрагдсан автомашины 57.9 хувь буюу 310.4 мянга нь баруун гар талдаа хүрдтэй байна. Техникийн үзлэгт хамрагдсан автомашины төрлийг хүрдний байрлалаар нь задлан харвал нийт автомашины 72.4 хувийг эзэлж байгаа суудлын тэрэгний 24.7 хувийг зүүн, 75.3 хувийг баруун, ачааны автомашины 86.6 хувийг зүүн, 13.4 хувийг баруун, автобусны 93.7 хувийг зүүн, 6.3 хувийг баруун гар талдаа хүрдтэй автомашин эзэлж байна.

Зураг 13. Үзлэгт хамрагдсан автомашин хүрдний байрлалаар, аймгаар



1.5.2 Үзлэгт хамрагдсан автомашины өмчийн хэлбэр

Өнгөрсөн жил үзлэгт хамрагдсан нийт автомашины 82.1 хувийг иргэд, 14.6 хувийг компани болон нөхөрлөл, хоршоо, 1.6 хувийг төрийн болон орон нутгийн өмч, 1.1 хувийг төрийн бус байгууллага, 0.4 хувийг гадаадын иргэд, 0.1 хувийг дипломат болон олон улсын байгууллагууд тус тус эзэмшиж байна. Иргэдийн эзэмшлийн автомашин 2016 оноос 6.8 хувь буюу 28.2 мянга, компани болон нөхөрлөл, хоршооных 11.2 хувь буюу 7.8 мянга, төрийн бус байгууллагынх 24.3 хувь буюу 1.2 мянга, гадаадын иргэнийх 2.1 хувь буюу 43 ширхгээр өссөн бол төрийн болон орон нутгийн байгууллагынх 0.7 хувь буюу 58 ширхэг, дипломат, олон улсын байгууллагынх 0.8 хувь буюу 5 ширхгээр тус тус буурсан байна.

Хүснэгт 8. Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо, өмчийн хэлбэрээр

	2014	2015	2016	2017
Амины автомашин	361794	405 601	412 290	440 497
Гадаадын иргэний	-	2 054	2 022	2 065
Дипломат, олон улсын байгууллагын	615	596	638	633
Компани, хоршоо, нөхөрлөлийн	62 204	60 848	70 498	78 367
Төрийн болон орон нутгийн өмчийн	8 235	8 480	8 793	8 735
Төрийн бус байгууллагын	4 829	4 470	4911	6 102
Нийт	437 677	482 049	499 152	536 399


Иргэдийн эзэмшлийн автомашины хувьд 76.3 хувийг суудлын, 20.4 хувийг ачааны машин, 2.4 хувийг автобус, 0.6 хувийг тусгай зориулалттай автомашин эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад суудлын автомашин 7.6 хувь, ачааны автомашин 5.8 хувь, тусгай зориулалтын автомашин 1.3 хувиар өсөж, автобус 3.3 хувиар буурчээ. Иргэдийн өмчлөлийн автобусны тоонд микро автобусны тоог оруулж тооцсон.

Иргэдийн эзэмшлийн автомашины тоог 2016 онтой харьцуулахад Дорноговь аймагт хамгийн өндөр буюу 23.0 хувиар өссөн бол Говь-Алтай аймгийн хувьд энэ тоо 9.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Баянхонгор, Өвөрхангай, Дархан-Уул, Төв, Сүхбаатар аймгаас бусад аймгийн хувьд 2016 оны дүнтэй харьцуулахад өссөн дүнтэй байна.

1.5.3 Үзлэгт хамрагдсан автомашины ашиглалтын хугацаа, хөдөлгүүрийн багтаамж

Автотээврийн хэрэгслийн тоо эрс олширч, авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа нь байгаль орчинд төдийгүй иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байдаг билээ. Нөгөөтэйгүүр манай улсад орж ирэх автомашины тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа бөгөөд хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн 34.1 хувийг 1500/см³/ хүртэл хөдөлгүүрийн багтаамжтай тээврийн хэрэгсэл эзэлж байна. Мөн 1501-2500 /см³/ хүртэл хөдөлгүүрийн багтаамжтай тээврийн хэрэгсэл 37.8 хувийг эзэлж байгаа бол 4501 /см³/ дээш хөдөлгүүрийн багтаамжтай тээврийн хэрэгсэл 9.9 хувийг эзэлж байна.

Зураг 14. Үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн багтаамж, хувиар



Сүүлийн 3 жилийн дүнг зургаас харахад 1500 /см³/ хүртэлх хөдөлгүүрийн багтаамжтай автомашины тоо тогтмол өсөж байгаа бөгөөд 1501-ээс 4500 хүртэлх хөдөлгүүрийн багтаамжтай автомашины тоо буурсаар байна. 1500 /см³/ хүртэлх хөдөлгүүрийн багтаамжтай автомашины 70.8 хувийг Япон улсад үйлдвэрлэсэн Тоёота маркийн автомашин эзэлж байгаа бөгөөд үүнээс Приус загварын автомашин 62.7 хувийг эзэлж байна.

Техникийн үзлэгт 2017 онд хамрагдсан автомашиныг ашигласан хугацаагаар нь авч үзвэл, 422.3 мянга нь 10-аас дээш, 104.1 мянга нь 4-9 жил, 10.0 мянга нь 3 жил хүртэл байгаа бөгөөд 10-аас дээш жил ашигласан автомашин 2010 оноос хойш 2.2 дахин, өнгөрсөн оноос 7.3 хувиар өсөж харин 3 хүртэл жил ашигласан автомашин 2010 оноос 16.3 хувь, өнгөрсөн оноос 6.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 9. Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо, ашигласан хугацаагаар


	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
3 хүртэл жил	8 585	10 770	20 325	26 492	21 430	14 562	10 652	9 981
4-9 жил	54 283	46 114	79 022	79 470	86 337	98 019	94 739	104 075
10-аас дээш	191 618	255 658	246 126	278 902	329 910	369 468	393 761	422 343
Бүгд	254 486	312 542	345 473	384 864	437 677	482 049	499 152	536 399
Дүнд эзлэх хувь								
3 хүртэл жил	3.4	3.4	5.9	6.9	4.9	3.0	2.1	1.9
4-9 жил	21.3	14.8	22.9	20.6	19.7	20.3	19.0	19.4
10-аас дээш	75.3	81.8	71.2	72.5	75.4	76.6	78.9	78.7

Үзлэгт хамрагдсан автомашины 1.9 хувийг 3 хүртэлх жил ашигласан автомашин эзэлж байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь 2010 оноос хойших хамгийн бага үзүүлэлт болж байна. Харин эсрэгээрээ 10-аас дээш жил ашигласан автомашин 78.7 хувийг эзэлж, жилээс жилд өссөөр байна.

1.5.4 Үзлэгт хамрагдсан автомашины тоо, үйлдвэрлэсэн улсаар, маркаар

Монгол Улсад 22 улсын 307 маркийн автомашин 2017 оны үзлэгт хамрагдсан байна. Нийт автомашины 62.1 хувь Япон улсад үйлдвэрлэгдсэн ба үүний дараагаар Солонгос улсад үйлдвэрлэгдсэн автомашин 26.0 хувийг эзэлж байна. ОХУ болон БНХАУ-д үйлдвэрлэгдсэн автомашин 9.1 хувийг эзэлж байгаа бөгөөд ихэвчлэн хүнд даацын, их багтаамжийн ачааны автомашин байна. Үлдсэн 2.8 хувьд АНУ, Герман, Итали зэрэг улсын автомашин багтаж байна.

Зураг 15. Үзлэгт хамрагдсан автомашины тоо, үйлдвэрлэсэн улсаар



Өнгөрөгч 2017 онд техникийн үзлэгт хамрагдсан Япон улсад үйлдвэрлэсэн автомашин 2016 оноос 10.6 хувиар, Солонгос улсад үйлдвэрлэсэн автомашин 1.2 хувь, Хятад улсад үйлдвэрлэсэн автомашин 24.4, Швед улсад үйлдвэрлэсэн автомашин 52.2 хувиар өссөн бол ОХУ-д үйлдвэрлэсэн автомашин 5.7 хувь, Англи улсад үйлдвэрлэсэн автомашин 5.1 хувиар буурсан байна.

1.6 Автомашины импорт


Гадаад худалдааны мэдээгээр улсын гаалиар 2017 онд нийт 48 870 суудлын автомашин, 14 155 ачааны автомашин, 1201 нийтийн тээврийн хэрэгсэл, 257 трактор болон өөрөө явагч механизм шинээр орж ирсэн ба 2016 оныхоос нийтийн тээврийн хэрэгсэл 24.6 хувь, суудлын автомашин 29.5 хувь, ачааны автомашин 2 дахин өссөн байна. Монгол Улс түүхэндээ 2011 онд хамгийн их буюу 57.6 мянган суудлын автомашин, 24.8 мянган ачааны автомашин импортлосон бол өнгөрөгч онд 2011 оноос хойших хамгийн их автомашин импортлосон байна.

Хүснэгт 10. Импортлосон автомашины тоо, төрлөөр

	Нийтийн тээврийн хэрэгсэл	Суудлын автомашин	Ачааны машин	Төрөл бүрийн трактор, өөрөө явагч механизм	Нийт
2010	1 634	26 378	12 221	996	41 229
2011	2 807	57 580	24 853	1 044	86 284
2012	2 432	46 409	22 438	9 421	80 700
2013	1 800	44 680	17 995	369	64 844
2014	1 291	41 246	12 505	285	55 327
2015	870	37 086	7 675	588	46 219
2016	964	37 735	6 836	877	46 412
2017	1 201	48 870	14 155	257	64 483

2017 онд нийтийн тээврийн хэрэгслийн 68.5 хувь нь БНСУ, 17.9 хувь нь ОХУ, 7.7 хувь нь Япон улс, үлдсэн 5.8 хувийг БНХАУ, Турк, Франц, ХБНГУ-аас худалдан авсан бол суудлын автомашины хувьд 92.2 хувийг Япон улс, 6.0 хувийг БНСУ-аас импортлосон байна. Харин ачааны автомашины 50.5 хувийг БНСУ, 28.1 хувийг БНХАУ, 15.0 хувийг Япон улсаас оруулж ирсэн байна. Дээрх тооноос харахад, суудлын тэрэгний дийлэнхийг Япон улсаас авч байгаа бол ачааны болон нийтийн тээврийн хэрэгслийг БНСУ-аас импортлосон байна.

Зураг 16. Импортоор оруулж ирсэн суудлын автомашины тоо, мянган ширхэг



1.7 Агаарын тээвэр


Хүн ам тархан суурьшсан, газар нутгийн хэмжээ томтой манай улсын хувьд агаарын тээврийн үйлчилгээ маш чухал. Монгол Улсад 2017 онд нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлгийн тоо 16 ширхэг тоологдсон бөгөөд нийт том оврын агаарын хөлөг 3, дунд оврын агаарын хөлөг 6, бага оврын агаарын хөлөг 7 ширхэг байна.

Манай улс ОХУ, БНХАУ-тай агаарын 15 хаалгаар холбогдож, нийт 62 агаарын замыг ашиглаж байна. Өнгөрсөн онд олон улсад 20 чиглэл, орон нутагт 13 чиглэлд тогтмол нислэг үйлдсэн бөгөөд дотоодын нислэгийн тоо 5673-т хүрсэн бөгөөд дотоодын нислэгийн дүнд уул уурхайн салбарын хөгжлийг дагаад уул уурхайн зориулалттай нислэг тогтмол нэмэгдсээр байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын статистик мэдээгээр улсын төсөвт 2017 онд аэронавигациас 147.6 тэрбум төгрөгийн орлого орж, нэгдсэн төсвийн татварын бус орлогод 12.7 хувийг эзэлж байна. Аэронавигациас олсон орлого 2015 оныхоос 52.0 тэрбум төгрөг буюу 54.4 хувь, өмнөх оныхоос 31.8 тэрбум төгрөг буюу 27.4 хувиар өссөн байна.

Монгол Улсын агаарын зайд дамжин өнгөрөх нислэг, олон улсын нислэгийн эрэлт сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж байна. Манай улсын агаарын зайгаар 2017 онд дамжин өнгөрөлтийн нийт 110.9 мянган нислэг, 7.9 мянган олон улсын буулт, хөөрөлт, 5.7 мянган орон нутгийн буулт, хөөрөлт үйлдэгдсэн ба өнгөрөлтийн нислэгийн тоо өмнөх оноос 11.8 хувь, олон улсын буулт, хөөрөлт 17.8 хувь, орон нутгийн буулт, хөөрөлт 14.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 17. Дамжин өнгөрөлт, олон улсын болон орон нутгийн нислэгийн тоо



Эх үүсвэр: Иргэний Нисэхийн Ерөнхий Газар

2017 оны жилийн эцсийн байдлаар өнгөрөлтийн нислэгийн гүйцэтгэсэн авиа компани болон сараар гарган харахад хамгийн их буюу 13.6 хувийг Эйр чайна компанийн нислэг эзэлж байгаа ба сарын дунджаар 1260 нислэг, өдөрт дунджаар 40 өнгөрөлтийн нислэгийн үйлчилгээ үзүүлж байна.

1.8 Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврээр 2017 онд 138 зүтгүүр, 3153 ачааны вагон, 282 суудлын вагонтойгоор үйл ажиллагаа явуулжээ.

Улсын хэмжээнд хойд хилээс урд хил хүртэл 5 чиглэлийн нийтдээ 63 өртөө байдаг бөгөөд Улаанбаатар хотоос урд хил хүртэл 38, хойд хил хүртэл 25 өртөө байгаа бөгөөд нийт 1815 километр замтай байна.

Тээврийн салбарын эдийн засгийн үндсэн үзүүлэлт

2

Үндэсний статистикийн хороо нь автотээврийн салбарын статистикийн мэдээ, тайланг аж ахуйн нэгж, байгууллагаас аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газраар дамжуулан, агаарын болон төмөр замын тээврийн мэдээг аж ахуйн нэгжүүдээс нь шууд авч нэгтгэн боловсруулж нийтэд тархааж байна. Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндэс болсон тээврийн салбарын эдийн засгийн үндсэн үзүүлэлт гэсэн бүлэгт салбарын ДНБ-д эзлэх хувь, аж ахуйн нэгж байгууллагын тоо, ажиллагчдын тоо, тээврийн орлого гэсэн үзүүлэлтийн талаар авч үзнэ. Эдийн засагт тээвэр, харилцаа холбооны салбарын оруулж буй хувь нэмэр буюу ДНБ-д эзлэх хувийг Үндэсний статистикийн хорооноос жил бүр тээврийн албан болон албан бус сектороор тооцож гаргадаг. Тээврийн албан секторт ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж байна. Хувиараа тээвэр эрхлэгчдэд хувийн микро автобус, ачааны машин, суудлын автомашинаар зорчигч болон ачаа тээвэрлэдэг иргэдийг хамруулж байгаа бөгөөд албан бус секторт хувиараа тээвэр эрхлэгчдийг оруулж байна.

ҮСХ аж ахуйн нэгжийн бүртгэлийн сан буюу бизнес регистрийн санд 2017 оны эцсийн байдлаар тээвэр, агуулахын салбарт 2929 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэний 1468 буюу 50.1 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгжийн тоонд энэ салбарынх 1.9 хувийг эзэлж байна. Тээвэр, агуулах болон холбооны салбарын нийт аж ахуйн нэгжийн тоо 2016 оныхоос 12.9 хувиар, тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 11.0 хувиар тус тус өсжээ.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2017 онд урьдчилсан дүнгээр 27.2 их наяд төгрөг болсон ба үүнээс 1.3 их наяд төгрөг буюу 4.8 хувь нь тээвэр, агуулахын салбарт ногдож байгаа бөгөөд 2016 оноос 0.4 пунктээр буурсан байна.

Зураг 18. ДНБ-нд эзлэх хувь, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр



Улсын хэмжээнд 2017 онд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нийт үйлдвэрлэл, үйлчилгээний 78.7 хувийг бүрдүүлсэн бөгөөд тээврийн салбарын хувьд 57.9 хувийг эзэлж байгаа нь өнгөрөгч оноос 4.0 пунктээр өссөн байна. Үлдсэн 42.1 хувийг “МИАТ”, “УБТЗ” зэрэг төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагууд бүрдүүлсэн байна.

2.1 Тээврийн салбарын ажиллагчдын тоо, цалин

Тээврийн салбарт ажиллаж буй 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2017 онд хөдөө аж ахуй, боловсрол, худалдаа, боловсруулах үйлдвэрийн салбарын дараагаар орж 72.7 мянган хүн ажилласан нь өмнөх оноос 6.8 мянга хүнээр өссөн байна. Энэ нь уул уурхайн салбарын үйл ажиллагаа эрхлэлттэй холбоотой бөгөөд нүүрсний тээвэрлэлт өссөнөөс үүдэлтэй.


Хүснэгт 11. Тээвэр болон агуулахын салбарын ажиллагчдын тоо, мянган хүн

	Хөдөө аж ахуй	Бөөний болон жижиглэн худалдаа	Боловсрол	Тээвэр болон агуулах
2007	373.8	116.3	60.4	68.9
2008	365.2	94.8	71.3	54.0
2009	348.8	160.3	74.9	68.7
2010	346.6	146.2	85.3	76.5
2011	342.8	152.5	85.5	75.8
2012	370.0	131.3	86.3	56.1
2013	329.1	156.0	89.8	65.9
2014	310.7	170.2	89.6	69.8
2015	327.6	178.2	89.0	72.7
2016	348.4	172.7	95.0	65.9
2017	356.4	204.5	98.9	72.7

Эх үүсвэр: ҮСХ, Ажиллах хүчний судалгаа

2017 онд тээврийн салбарт 61.4 мянган эрэгтэй, 11.3 мянган эмэгтэй хүн ажиллаж өмнөх оноос эрэгтэй ажиллагчид 22.8 хувиар өссөн бол эмэгтэй ажиллагчид 2.8 хувиар буурсан байна. Мөн 2007 оны дүнтэй харьцуулахад эрэгтэй ажиллагчид 21.1 хувиар өсөж, эмэгтэй ажиллагчид 16.6 хувиар буурсан байна.

Зураг 19. Ажиллагчдын тоо, хүйсээр



Агаарын тээврийн салбарт нийтдээ 3.7 мянган ажиллагчид 2017 онд ажилласан ба үүнээс 106 нисгэгч, 235 инженер техникийн ажиллагчид байгаа бол төмөр замын салбарт 14.9 мянган хүн ажиллаж байгаагаас ашиглалтын 9529 ажиллагчид байна.

Тээврийн салбарын ажиллагчдын дундаж цалин 2017 онд 1106.1 мянган төгрөг болж, өнгөрсөн оноос 4.9 хувь, 2010 оноос 2.6 дахин, 2007 оноос 5.4 дахин өссөн байна.

Хүснэгт 12. Тээврийн салбарын ажиллагчдын сарын дундаж цалин, мянган төгрөг

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2007	205.4	225.3	184.3
2008	277.9	317.8	231.7
2009	297.9	315.4	275.7
2010	421.0	442.2	394.0
2011	509.8	564.2	436.5
2012	560.0	587.3	529.3
2013	817.3	922.5	593.7
2014	900.3	948.9	816.8
2015	1 014.2	1 076.0	903.2
2016	1 054.9	1 101.0	964.6
2017	1 106.1	1 111.2	1 093.9

Эх үүсвэр: УСХ, Ажиллах хүчний судалгаа

Тээврийн салбарын дийлэнх хувийг эрэгтэй ажиллагчид эзэлдэг ба тэдний дундаж цалин өнгөрсөн онд 1111.2 мянган төгрөг болж эмэгтэй ажиллагчдын дундаж цалин 1093.9 мянган төгрөгт хүрч өнгөрсөн оноос эрэгтэй ажиллагчдын цалин 0.9 хувь, эмэгтэй ажиллагчдын цалин 13.4 хувиар өсжээ. Салбарын эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин 2012 оноос, эмэгтэй ажиллагчдын цалин 2013 оноос эхлэн эрчимтэй өсөж эхэлсэн байна.

2.2 Тээврийн салбарын орлого бүрдэлт

Тээврийн салбарын 2017 оны нийт орлого 1422.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 230.8 тэрбум төгрөг буюу 19.4 хувиар, 2012 оноос 381.2 тэрбум төгрөг буюу 36.6 хувь, 2010 оноос 828.7 тэрбум төгрөг буюу 2.4 дахин өсжээ. 2017 оны нийт орлогын 35.6 хувь нь авто тээврээс, 37.3 хувь нь төмөр замын тээврээс, 27.1 хувь нь агаарын тээврээс, 0.02 хувь нь усан замын тээврээс орж 2016 оноос төмөр замын тээврийн салбараас орсон орлогын эзлэх хувь 0.6 пункт, агаарын тээврийнх 3.0 пункт, усан замын тээврийнх 0.001 пунктээр нэмэгдэж, авто тээврийн орлого 3.6 пунктээр буурсан байна.

Хүснэгт 13. Тээврийн салбарын орлого, тэрбум төгрөг


	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
БҮГД	342.3	419.2	465.6	593.6	761.0	1041.1	1045.0	1038.3	987.9	1191.5	1422.3
Жилийн өсөлт, бууралт	109.8	122.5	111.1	127.5	128.2	136.8	100.4	99.4	95.1	120.6	119.4

Авто тээврийн салбарын нийт орлого 2017 онд 506.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 39.3 тэрбум төгрөг буюу 8.4 хувь, 2012 оноос 88.8 тэрбум төгрөг буюу 21.3 хувь, 2010

оноос 334.2 тэрбум төгрөг буюу 2.9 дахин өсжээ. Авто тээврийн салбарын орлого 2016 оноос өсөхөд ашигт малтмалын бүтээгдэхүүн тээвэрлэлт голчлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн салбарын нийт орлого 2017 онд 530.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 93.2 тэрбум төгрөг буюу 21.3 хувь, 2012 оноос 113.5 тэрбум төгрөг буюу 27.3 хувь, 2010 оноос 223.1 тэрбум төгрөг буюу 72.7 хувиар өсжээ. Төмөр замын тээврийн орлого 2016 оноос өсөхөд төмрийн хүдрийн тээвэрлэлт голчлон нөлөөлсөн байна.

Зураг 20. Тээврийн салбарын орлого, салбараар, тэрбум төгрөг




Агаарын тээврийн салбарын нийт орлого 2017 онд 385.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 98.2 тэрбум төгрөг буюу 34.2 хувь, 2012 оноос 178.6 тэрбум төгрөг буюу 86.3 хувь, 2010 оноос 271.0 тэрбум төгрөг буюу 3.4 дахин өсжээ. Агаарын тээврийн орлого өнгөрсөн оноос өсөхөд уул уурхайн захиалгат болон орон нутгийн зорчигч тээвэрлэлт голлон нөлөөлсөн байна.

Зорчигч тээврийн үндсэн үзүүлэлт

3

Энэхүү бүлэгт 2017 онд авто тээвэр, төмөр зам, агаарын тээврээр тээсэн зорчигч тээврийн өнөөгийн байдал, өнгөрсөн жилүүдтэй харьцуулсан тоон мэдээллийг танилцуулах болно. Бүх төрлийн тээврийн хэрэгслээр 2017 онд давхардсан тоогоор 215.7 сая хүн зорчиж, зорчигч эргэлт 4377.7 сая хүн километрт хүрсэн байна. Зорчигчдын тоог өмнөх онуудтай харьцуулахад 2007 оноос 2.7 хувиар өсөж, 2010 оноос 14.0 хувь, өмнөх оноос 18.3 хувиар буурсан байна. Зорчигч эргэлт 2007 оноос 34.2 хувь, 2010 оноос 21.3 хувь, өмнөх оныхоос 7.5 хувиар өссөн байна.

Зураг 21. Бүх төрлийн тээврийн зорчигчдын тоо, сая хүн



Тээврийн салбараар 2017 онд нийт 215.7 сая хүн зорчсоноос 98.4 хувь нь авто тээврээр, 1.2 хувь нь төмөр замын тээврээр, 0.4 хувь нь агаарын тээврээр, 0.01 хувь нь усан замын тээврээр зорчсон байна.

Хүснэгт 14. Зорчигчдын тоо, салбараар, сая хүн


Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт	209.9	231.6	232.5	250.7	296.2	318.0	307.9	344.2	260.0	264.0	215.7
Төмөр зам	4.5	4.3	3.1	3.5	3.8	4.0	3.8	3.3	2.8	2.7	2.6
Авто зам	205.0	226.9	229.0	246.7	291.8	313.2	303.4	340.2	256.5	260.7	212.2
Агаар	0.4	0.4	0.3	0.4	0.6	0.8	0.8	0.7	0.6	0.7	0.8
Усан зам			-	0.01	0.01	0.04	0.03	0.04	0.05	0.03	0.02

3.1 Агаарын тээвэр

Өнгөрсөн онд агаарын тээврээр зорчсон 833.9 мянган хүн болж, 2007 оныхоос 445.5 мянган хүн буюу 2.1 дахин, 2010 оныхоос 435.7 мянган хүн буюу 2.0 дахин, өмнөх оныхоос 160.7 мянган хүн буюу 23.8 хувиар өсөв. Зорчигчдыг улирлаар харуулбал 2017 оны эхний улиралд 151.0 мянга, II улиралд 194.9 мянга, III улиралд 292.7 мянга, IV улиралд 195.3 мянган зорчигч тээвэрлэсэн байна.


Агаарын тээврээр дотоодод зорчсон зорчигчдын тоо 2017 онд 314.6 мянга, олон улсад зорчигчид 519.3 мянган хүн болж дотоод зорчигчид өнгөрсөн оноос 32.9 хувь, 2010 оноос 2.6 дахин өссөн бол 2012 оноос 4.2 хувиар буурч, гадаад зорчигчид өнгөрсөн оноос 19.0 хувь, 2010 оноос 87.4 хувь, 2012 оноос 17.6 хувиар өссөн байна. 2017 оны олон улсын зорчигч тээвэрлэлтийн өсөлтөд “МИАТ ХК” нь Улаанбаатар-Бангкок-Улаанбаатар, Улаанбаатар-Бусан-Улаанбаатар чиглэлд, “Хүннү Эйр ХХК” нь Улаанбаатар-Улаан-Үүд-Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэж эхэлсэн, мөн Улаанбаатар-Эрээн-Улаанбаатар чиглэлд хуваарьт нислэг нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Мөн орон нутгийн зорчигч тээвэрлэлт өссөн хэдий ч нийт зорчигчийн 67 хувийг уул уурхайн чиглэлийн захиалгат нислэгийн зорчигч тээвэрлэлт эзэлж байна. Үүнээс үзэхэд орон нутгийн зорчигч тээврийн өсөлт нь уул уурхайн салбарын өсөлтөөс шууд хамааралтай байна.

Зураг 22. Агаарын зорчигч тээвэр, мянган хүн



Агаарын тээвэр нь аялал жуулчлалын салбараас нэлээд хамааралтай байдаг бөгөөд 2012-2017 оны 5 жилийн тоо мэдээлэлд үндэслэн агаарын тээврийн зорчигч тээвэрлэлтийн улирлын хэлбэлзлийг тооцож үзэв.

Зураг 23. 2017 оны агаарын зорчигч тээвэрлэлтийн сарын индекс




Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо жилийн 6-8 дугаар саруудад өсөж, харин 10-2 дугаар саруудад буурч байна. Жилийн 7, 8, 9 дүгээр сард хамгийн өндөр өсөлттэй байгаа нь энэ улиралд жуулчдын тоо нэмэгдсэн, мөн гадаад улсад сурч буй оюутнуудын зорчих урсгал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.2 Төмөр зам

Өнгөрсөн онд төмөр замын тээврээр зорчсон зорчигчид 2.6 сая хүн болж, 2007 оныхоос 1.8 сая хүн буюу 41.3 хувь, 2010 оныхоос 886.0 мянган хүн буюу 25.2 хувь, өмнөх оныхоос 15.2 мянган хүн буюу 0.6 хувиар буурав.

Төмөр замын тээврээр дотоодод зорчсон зорчигчдын тоо 2017 онд 2.5 сая, олон улсад зорчигчид 104.8 мянган хүн болж дотоод зорчигчид өнгөрсөн оноос 8.7 хувь, 2010 оноос 27.3 хувь, 2012 оноос 38.5 хувиар буурч, гадаад зорчигчид өнгөрсөн оноос 0.2 хувь, 2010 оноос 25.1 хувь, 2012 оноос 34.1 хувиар буурчээ.


Зураг 24. Төмөр замын зорчигчдын тоо, мянган хүн



Сүүлийн жилүүдэд төмөр замын зорчигчдын тоо тогтмол буурч байгаа нь авто замын дэд бүтэц хөгжиж, иргэд хувийн машин болон хот хооронд зорчигч тээврийн унаагаар үйлчлүүлэх нь нэмэгдсэнтэй холбоотой байна. Зорчигчдыг улирлаар задлан харуулбал 2017 оны эхний улиралд 638.1 мянга, II улиралд 655.6 мянга, III улиралд 703.7 мянга, IV улиралд 630.3 мянган зорчигч төмөр замаар зорчсон байна.

Төмөр замын тээвр олон тооны зорчигчийг цаг уурын нөхцөлөөс шалтгаалахгүйгээр холын зайд, аюулгүй тээвэрлэхэд тохиромжтой бөгөөд 2012-2016 оны 5 жилийн тоон мэдээлэлд үндэслэн төмөр замын тээврийн зорчигч тээвэрлэлтийн сарын хэлбэлзлийг тооцож үзэв.

Зураг 25. Төмөр замын тээврийн 2017 оны зорчигч тээвэрлэлтийн сарын индекс



Саруудын өөрчлөлтийн хандлагыг харвал (зураг 25) 5-8 дугаар саруудад өсөж, өвлийн саруудад буюу 12,1,2,3 дугаар саруудад буурсан байна. Зуны улирлын 6, 7, 8 дугаар сард зорчигч тээвэрлэлтийн улирлын индекс хамгийн өндөр хэмжээнд хүрдэг байна.

3.3 Авто тээвэр

Авто тээврээр 2017 онд давхардсан тоогоор 212.2 сая хүн зорчиж 2000 оныхоос 123.8 сая хүн буюу 2.4 дахин өссөн бол 2010 оныхоос 34.5 сая хүн буюу 14.0 хувь, өмнөх оныхоос 48.5 сая хүн буюу 18.6 хувиар буурсан байна.

Зураг 26. Авто тээврийн зорчигчдын тоо, давхардсан тоогор, сая хүн



Нийт авто тээврээр зорчсон иргэдийн 15.0 сая нь хөдөө орон нутагт зорчсон бол 197.2 сая нь хот доторх нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон байна. Авто тээврээр орон нутагт зорчсон зорчигчид өнгөрсөн оноос 1.0 сая хүн буюу 7.5 хувиар өссөн бол хот доторх нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зорчигч 49.5 сая хүнээр буюу 20.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 15. Орон нутгийн зорчигчдын тоо, мянган хүн

	2013	2014	2015	2016	2017
Баруун бүс	642.8	645.4	231.4	210.8	234.2
Баян-Өлгий	32.7	18.9	20.3	9.3	22.5
Говь-Алтай	66.7	45.9	59.2	52.9	61.7
Завхан	384.0	394.0	10.8	13.9	14.3
Увс	53.4	111.5	58.3	74.0	66.1
Ховд	106.0	75.1	82.8	60.7	69.6
Хангайн бүс	8 546.8	8 363.6	6 427.9	6 230.0	5 700.1
Дорноговь	104.5	52.5	55.5	51.3	108.6
Архангай	41.9	64.8	53.0	69.2	77.2
Баянхонгор	97.5	1 386.3	671.9	610.7	385.2
Булган	55.5	52.8	33.4	33.5	35.4
Орхон	8 086.1	6 670.3	5 478.1	5 254.6	4 849.7
Өвөрхангай	94.8	67.2	55.8	92.4	109.8
Хөвсгөл	66.5	69.8	80.2	118.2	134.2
Төвийн бүс	9 999.6	47 836.1	9 057.5	7 391.8	8 921.3
Говьсүмбэр	12.2	13.9	22.1	24	25.3
Дархан-Уул	5 404.6	6 177.2	6 087.0	6 158.5	6 659.2
Дундговь	38.6	30.1	18.8	43.6	29.3
Өмнөговь	233.4	126.7	650.5	477.1	1 314.8
Сэлэнгэ	799	846.1	336.4	350.7	560.3
Төв	3 511.8	40 642.1	1 942.8	337.9	332.4
Зүүн бүс	136.3	128.2	136.5	126.5	148.1
Дорнод	29.2	33.7	32.6	35.3	40.3
Сүхбаатар	62.0	46.9	47.2	40.6	38.8
Хэнтий	45.1	47.6	56.7	50.6	69.0


Хүн амын төвлөрөл, дэд бүтцийн хөгжил зэрэг шалтгааны улмаас орон нутгийн зорчигчдын дийлэнх хувийг Хангайн бүс, Төвийн бүс эзэлж байгаа бөгөөд Дархан-Уул, Орхон аймгуудад авто тээврийн хэрэгслээр зорчих нь хамгийн их байна.

Орон нутгийн зорчигчдын тоог (Хүснэгт 15)-аас харвал сүүлийн жилүүдэд авто тээврийн хэрэгслээр зорчих зорчигчдын тоо Хангайн бүсэд буурах хандлагатай харагдаж байгаа нь хувьдаа авто машинтай иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой. Нөгөөтэйгүүр Баруун болон Зүүн аймгуудын зорчигчдын тоо өссөн нь өртөг бага, аюулгүй тээврийн үйлчилгээг сонгох зэрэг шалтгаан нөлөөлж байна.

Орон нутгийн зорчигчдод 2017 оны байдлаар 45 хүний суудалтай Их багтаамжийн автобус 639, 24-36 хүний суудалтай дунд багтаамжийн автобус 67, бага оврын автобус 17, суудлын автомашин 248 буюу нийт 971 тээврийн хэрэгсэл үйлчилж байна.

Хот хоорондын зорчигч тээвэрт явсан тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл: Их багтаамжийн тээврийн хэрэгсэл 65.8%, дунд багтаамжийн тээврийн хэрэгсэл 6.9%, бага багтаамжийн тээврийн хэрэгсэл 1.7%, суудлын тээврийн хэрэгсэл 25.5% хувийг тус тус эзэлж байна.

Зураг 27. Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгсэл



Монгол Улс ОХУ, БНХАУ, Казахстан улстай байгуулсан хэлэлцээрийн хүрээнд 2017 онд батлагдсан 10 чиглэлд 13 аж ахуйн нэгжтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулан 91 тээврийн хэрэгслээр 188.1 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд: Замын-Үүд-Эрээний чиглэлд 117.2 мянган зорчигч, Улаанбаатар-Эрээний чиглэлд 8.7 мянган зорчигч, Замын-Үүд-Бээжин чиглэлд 11.5 мянган зорчигч, Замын үүд-Хөх хот чиглэлд 8.1 мянган зорчигч, Дорнод-Манжуур /өнгөрсөн оны 2 улирлаас эхэлж явсан/ чиглэлд 1.2 мянган зорчигч, Улаанбаатраас-Улаан-Үүд чиглэлд 25.7 мянган зорчигч, Сэлэнгэ-Хиагт чиглэлд 7.3 мянган зорчигч, Сэлэнгэ-Улаан-Үүд чиглэлд 2.1 мянган зорчигч, Баян-Өлгий-Казакстаны чиглэлд 6.1 мянган зорчигчийг тус тус тээсэн байна.


3.4 Усан замын тээвэр

Усан замын тээвэр 1950-иад оноос 1980-аад оны сүүл хүртэл нэлээд эрчимтэй хөгжиж, 1 чирэгч, 3 чиргүүл онгоцоор ОХУ-аас импортолж буй өргөн хэрэглээний бараа, шатах тослох материал бусад ачааг Ханх, Хатгал боомтын хооронд Хөвсгөл нуураар тээвэрлэж баруун аймгуудыг хангаж байсан ба Сэлэнгэ мөрнөөр гол төлөв мод бэлтгэл, үр тарианы тээвэрлэлт хийгдэж байв.


Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос хойш ОХУ-аас импортлох барааны ачаа эргэлт буурч, өмч хувьчлагдсан, хөдлөх бүрэлдэхүүн хуучирсан, мөн байгаль орчны асуудлаас болж усан замын тээвэр 2000 оны дунд үе хүртэл зогсонги байлаа. Усан замын тээврээр 2017 онд 21.3 мянган хүн зорчиж өнгөрсөн оноос 13.5 мянган хүн буюу 38.8 хувь, 2012 оноос 17.9 мянган хүн буюу 45.7 хувиар буурсан бол 2010 оноос 10.2 мянган хүн буюу 91.9 хувиар өссөн байна.

Зураг 28. Усан замын тээврийн үндсэн үзүүлэлт

Дотоодын усан замын зорчигч тээвэр (2015-2017)



Усан замын тээврийн орлого, сая.төг (2015-2017)



Усан замын тээврийн мэдээгээр Хөвсгөл нуурт аялал жуулчлалын зориулалтаар үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, иргэний мэдээллийг авч байна.

Хөвсгөл нуурт 2006 оны үед иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын 10 хүрэхгүй усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол өнөөдөр 80 гаруй болж цаашид улам бүр нэмэгдэх хандлагатай болж байна. Мөн усан замын тээврийн хэрэгслээр аялал жуулчлалд хамрагдах гадаад, дотоодын иргэдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Ачаа тээврийн Үндсэн үзүүлэлт


4

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн хамаарал улам гүнзгийрч, бараа, бүтээгдэхүүний хэрэгцээ өсөж, үйлдвэрлэлт нэмэгдэж байгаагийн хэрээр түүнд шаардагдах түүхий эд, тухайлбал; ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, тэдгээрийг богино хугацаанд бага зардлаар тээвэрлэх хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна.

Аливаа тээврийн үйлчилгээ өөр өөрийн гэсэн сул болон давуу талтай байдаг бөгөөд төмөр замын тээвэр нь бага зардлаар олон тооны зорчигч, их хэмжээний ачааг холын зайд тээвэрлэхэд тохиромжтой байхад агаарын тээвэр нь богино хугацаанд өндөр зардалтайгаар хязгаарлагдмал тээвэрлэлтийг гүйцэтгэдэг. Харин авто тээврийн үйлчилгээ хаалганаас хаалганд хүргэх, богино болон дундын зайд үйлчилгээ үзүүлэхэд илүү тохиромжтой байдаг.

Манай улс 2017 онд бүх төрлийн тээврээр 54.0 сая тонн ачаа тээвэрлэж, ачаа эргэлт 19162.4 сая тонн километрт хүрэв. Тээсэн ачааг өмнөх онуудтай харьцуулахад 2007 оноос 2.3 дахин, 2010 оноос 83.5 хувь, өмнөх оноос 33.6 хувиар өсжээ. Ачаа эргэлт 2007 оныхоос 2.1 дахин, 2010 оныхоос 58.0 хувь, өмнөх оныхоос 15.3 хувиар өссөн байна.

Зураг 29. Ачаа тээвэр, тээврийн төрлөөр, сая тонн



2017 онд тээсэн ачааны 42.2 хувь нь төмөр замын тээвэр, 57.8 хувь нь авто тээвэр, 0.006 хувь нь агаарын тээврээр тээж өнгөрсөн оноос төмөр замын ачаа 7.3 пунктээр буурч, авто тээврээр тээсэн ачаа 7.3 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 16. Авто тээвэрлэлтийн бүтэц, тээврийн төрлөөр


	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Төмөр зам	60.4	61.3	57.3	57.1	41.8	40.4	49.7	47.3	53.4	49.5	42.2
Авто	39.5	38.7	42.7	42.9	58.1	59.6	50.3	52.7	46.6	50.5	57.8
Агаар	0.010	0.010	0.010	0.010	0.010	0.010	0.010	0.010	0.010	0.010	0.006

4.1 Агаарын тээвэр

Өнгөрсөн онд агаарын тээврээр гадаад болон дотоодод нийт 3.1 мянган тонн ачаа тээвэрлэсэн ба өмнөх оноос 13.8 тонн буюу 0.4 хувиар буурч, тээвэрлэсэн ачааны сүүлийн 10 жилийн дундаж өсөлт 8.4 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Агаарын тээврийн ачааг шуудан, тээш, ачаа гэж 3 ангилан авч үздэг ба 2017 онд 2.7 мянган тонн ачаа, 219.8 тонн шуудан, 115.4 тонн тээш тээж, өнгөрсөн оноос ачаа 2.2 хувиар өсөж, шуудан 14.6 хувь, тээш 24.0 хувиар буурсан байна.

Зураг 30. Агаарын тээврээр тээсэн ачаа




Агаарын тээврээр тээсэн ачаа 2008, 2009 онууд буюу дэлхийн эдийн засгийн хямралын үед буурч байгаад 2010 оноос нэлээд эрчимтэй өсөж 2014, 2015 онуудад дахин буурч, 2016 онд сэргэх хандлага ажиглагдаж, 2017 онд өмнөх оныхоо хэмжээнд ачаа тээсэн байна. Мөн 2014 болон 2015 онуудад гадаадын хөрөнгө оруулалт буурснаас шалтгаалан ачаа тээвэрлэлт буурчээ.

Агаараар тээсэн ачаа 2007 оноос 2.4 дахин, ачаа эргэлт 18.7 хувь, 2010 оноос 2.8 дахин, ачаа эргэлт 2.2 дахин өсөж, 2012 оноос 12.0 хувь, ачаа эргэлт 15.5 хувиар буурсан байна.


Агаараар тээсэн шуудан 2007 оноос 49.4 хувь, ачаа эргэлт 55.5 хувь, 2010 оноос 42.3 хувь, ачаа эргэлт 28.6 хувь, 2012 оноос 46.3 хувь, ачаа эргэлт 42.1 хувиар буурсан байна.

Зураг 31. Агаарын тээврээр тээсэн шуудан




Агаараар тээсэн тээш 2007 оноос 61.2 хувь, ачаа эргэлт 57.4 хувь, 2010 оноос 57.4 хувь, ачаа эргэлт 17.8 хувь, 2012 оноос 76.0 хувь, ачаа эргэлт 49.0 хувиар тус тус буурсан байна.

Зураг 32. Агаарын тээврээр тээсэн тээш



Агаарын тээврийн ачаа тээвэрлэлтийн сарын индексийг сүүлийн 5 жилийн байдлаар тооцож үзвэл 7-оос 9 дүгээр саруудад хамгийн өндөр бол 1-ээс 3 дугаар саруудад хамгийн доод түвшинд байна. Зуны улиралд аялал жуулчлалын үйл ажиллагаа идэвхжиж түүнийг дагаад агаарын тээврийн зорчигч, ачаа өсөж байна.


Зураг 33. Агаарын тээврийн 2017 оны ачаа тээвэрлэлтийн сарын индекс



4.2 Төмөр замын тээвэр

Манай улсын тээврийн салбарын ачаа тээвэрлэлтэд төмөр замын тээвэр голлох үүрэгтэй бөгөөд 2017 онд 22.8 сая тонн ачаа тээвэрлэж, 2016 оныхоос 14.1 хувь, ачаа эргэлт 9.1 хувиар өсжээ.

Зураг 34. Төмөр замаар тээсэн ачаа, сая тонн



2017 оны байдлаар нийт ачаа тээвэрлэлтэд төмөр замын тээврээр тээсэн ачаа 42.2 хувийг эзэлж 2007 оныхоос 18.3 пункт, 2010 оныхоос 15.0 пункт, 2012 оноос 1.8 пункт, өмнөх оныхоос 7.3 пунктээр буурчээ.

Хүснэгт 17. Төмөр замаар тээсэн ачаа, хэлбэрээр, мянган тонн

	2007	2008	2010	2012	2014	2015	2016	2017
Тээсэн ачаа	14,072.6	14,646.9	16,804.0	20,445.2	21,118.6	19,150.8	19,989.1	22,765.1
Дотоод	7,512.6	8,016.2	8,304.4	9,889.8	10,573.6	9,231.3	8,537.6	9,484.6
Экспорт	1,776.3	2,565.0	4,638.8	6,575.7	6,191.1	5,637.7	7,095.3	7,886.8
Импорт	1,310.4	1,727.3	1,546.2	2,445.5	2,288.7	2,188.2	1,994.0	2,302.7
Дамжин өнгөрсөн	3,473.3	2,338.4	2,314.6	1,534.2	2,065.2	2,093.6	2,362.3	3,091.0

Төмөр замын тээврээр дотоод 9.5 сая тонн, экспортод 7.9 сая тонн, импортын 2.3 сая тонн, дамжин өнгөрөлтийн 3.1 сая тонн ачааг тээсэн байна. Өнгөрсөн оноос дотоодын ачаа тээвэрлэлт 1.0 пункт, экспортын ачаа 0.9 пунктээр буурч, импортын ачаа 0.1 пункт, дамжин өнгөрөлтийн ачаа 1.8 пунктээр өсжээ.

Төмөр замын тээврийн ачаа эргэлт 2017 онд 13493.3 сая тонн километр болж, өнгөрсөн оноос 9.1 хувь, 2007 оноос 61.4 хувь, 2010 оноос 31.2 хувь, 2012 оноос 11.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 18. Төмөр замын тээврийн ачаа эргэлт


	Дотоод	Экспорт	Импорт	Дамжин өнгөрөх
2007	2 440.6	1 404.1	660.6	3 855.4
2008	2 662.8	2 132.5	870.6	2 595.6
2009	2 363.6	2 352.2	587.1	2 549.3
2010	2 631.2	4 315.9	770.4	2 569.2
2011	2 870.2	5 400.3	1 051.4	2 096.8
2012	3 291.7	5 909.6	1 238.5	1 703.0
2013	3 647.9	5 316.0	1 162.7	1 950.0
2014	3 532.3	5 585.8	1 063.2	2 292.3
2015	2 860.7	5 251.8	1 026.2	2 323.9
2016	2 292.4	6 524.1	932.3	2 622.1
2017	2 473.5	6 417.6	1 171.1	3 431.0

Экспорт, дамжин өнгөрөлтийн тээвэрлэлт сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа бол дотоодод болон импортын тээвэрлэлт буурсаар байна.

Төмөр замын тээврээр 2017 онд гадаад болон дотоодод нүүрс, нефть, барилгын материал, мод, модон материал, хүнс, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, уул уурхайн үйлдвэрийн бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүнийг тээснээс 47.1 хувь нь нүүрс, 36.0 хувь нь уул уурхайн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 6.8 хувь нь барилгын материал, 3.4 хувийн нефть, нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна. Өнгөрсөн оноос нүүрс тээвэрлэлт 3.8 пункт, нефтийн бүтээгдэхүүн 2.0 пункт, барилгын материал 0.3 пунктээр өссөн бол уул уурхайн үйлдвэрийн бүтээгдэхүүн 7.6 пунктээр буурсан байна. Төмөр замаар 2017 оны эхний

улиралд 4.8 сая тонн ачаа, II улиралд 5.5 сая тонн ачаа, III улиралд 6.0 сая тонн ачаа, IV улиралд 6.5 сая тонн ачаа тээвэрлэсэн байна.

Зураг 35. Төмөр замын тээврийн 2017 оны ачаа тээвэрлэлтийн сарын индекс




Төмөр замын тээврийн ачаа тээвэрлэлтийн сарын индексийг сүүлийн 5 жилийн байдлаар тооцож үзвэл 9-өөс 12 дугаар саруудад хамгийн өндөр бол 1-ээс 4 дүгээр саруудад хамгийн доод түвшинд байна.

4.3 Авто замын тээвэр

Сүүлийн жилүүдэд авто замын дэд бүтэц, уул уурхайн тээвэрлэлтийн өсөлтийг дагаад авто тээврийн салбарын эдийн засгийн үзүүлэлт тогтмол нэмэгдэж байна.

Авто тээврээр тээсэн ачаа 2017 онд 31.2 сая тонн болж, 2016 оныхоос тээсэн ачаа 10.8 сая тонн буюу 52.9 хувь, 2010 оноос 18.6 сая тонн буюу 2.5 дахин, 2012 оноос 1.0 сая тонн буюу 3.3 хувиар өссөн байна.

Зураг 36. Авто тээврээр тээсэн ачаа



Авто тээврийн ачаа эргэлт 2017 онд 5661.3 сая тонн километр болж, өнгөрсөн оноос 33.6 хувь, 2010 оноос 3.1 дахин, 2012 оноос 61.6 хувь, 2014 оноос 14.7 хувиар өсжээ.

2017 онд орон нутагт авто тээврээр тээсэн ачааны хэмжээгээр Төвийн бүс тэргүүлж байна. Төвийн бүсийг өндөр хувь эзлэхэд Өмнөговь аймгийн уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт нөлөөлсөн байна. 2017 онд Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурван тэс, Ноён зэрэг сумдад үйл ажиллагаа явуулж байгаа Таван толгой, Оюутолгой, Ухаа худаг, Нарийн сухайт, Ноён уулын уурхайгаас нүүрс, зэс зэрэг бүтээгдэхүүнүүдийг

Гашуун сухайт, Шивээхүрэнгийн боомтоор дамжуулан БНХАУ-руу тээвэрлэж байна. Мөн Дорнод аймгийн Матад сумын Тамсагийн сав газраас Халх гол сумын Баян хошуу боомтоор газрын тос, Ховд аймгийн Дарви сумын Хөшөөтийн нүүрсний уурхайгаас Булган сумын Ярантын боомт хүртэл нүүрс тээвэрлэж байна.

Хүснэгт 19. Орон нутгийн ачаа тээвэр, мянган тонн

	2013	2014	2015	2016	2017
Баруун бүс	1 377.6	2 436.1	1 442.6	1 525.6	716.6
Баян-Өлгий	78.2	12.2	20.8	46.6	14.2
Говь-Алтай	944.3	2 062.9	864.8	38.7	44.3
Завхан	34.2	37.8	39.2	38.6	33.3
Увс	49.7	56.6	58.3	56.2	41.2
Ховд	271.2	266.6	459.5	1 345.5	583.6
Хангайн бүс	1 102.6	421.7	681.5	792.4	1 861.8
Дорноговь	793.6	129.3	468.5	565.4	1542.9
Архангай	23.1	86.2	33.0	20.2	29.6
Баянхонгор	209.2	55.9	28.1	22.1	110.6
Булган	3.2	11.6	9.6	10.3	9.2
Орхон	73.1	128.9	132.6	169.0	153.7
Өвөрхангай	0.2	2.4	3.2	1.8	2.7
Хөвсгөл	0.2	7.4	6.5	3.6	13.1
Төвийн бүс	15 580.3	17 747.6	11 929.9	15 608.5	24 459.7
Дархан-Уул	282.5	305.7	294.8	285.4	156.2
Өмнөговь	13 000.3	14 734.9	10 886.4	15 216.1	24 212.1
Сэлэнгэ	8.1	8.7	1.4	5.9	4.3
Төв	2 289.4	2 698.3	747.3	101.1	87.1
Зүүн бүс	679.2	994.4	1 253.9	1 376.4	1 038
Дорнод	334.8	543.9	903.3	962.2	708.2
Сүхбаатар	143.2	106.3	101.2	146.4	134.3
Хэнтий	201.2	344.2	249.4	267.8	195.5

Зам тээврийн осол, зөрчлийн үндсэн үзүүлэлт

Энэхүү бүлэгт зам тээврийн осол, зөрчил, шалтгаан, нөхцөл байдал, учирсан хохирол, зам тээврийн ослын гаралт, хүүхэд өртсөн байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн захиргааны зөрчлийн үзүүлэлт, зам тээврийн ослын холбогдолтой бусад тоо баримтуудыг нэгтгэн оруулав.


“Зам тээврийн осол” зам тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг хэлнэ.

Улсын хэмжээнд 2017 онд зам тээврийн ослын шинжтэй дуудлага 92261-г хүлээн авч 36591 зам тээврийн осол бүртгэн шалгасан байна.

5.1 Зам тээврийн ослын шинжтэй дуудлага

Улсын хэмжээнд 2016 онд 94733 дуудлага хүлээн авч байсан бол 2017 онд 92261 зам тээврийн ослын шинжтэй дуудлага хүлээн авсан байна. Зам тээврийн ослын шинжтэй дуудлагын 95.6 хувь буюу 88240 нь нийслэл Улаанбаатар хотод бол 4.4 хувь буюу 4021 дуудлага нь орон нутагт бүртгэгдсэн байна. Ослын шинжтэй дуудлагыг дүүргээр задлан харвал Баянзүрх 22.5 мянга, Баянгол 17.2 мянга, Сүхбаатар 15.2 мянга, Сонгинохайрхан дүүрэгт 13.6 мянган дуудлага бүртгэгдсэн байна.


Зураг 37. Зам тээврийн ослын шинжтэй дуудлага /2017/



5.2 Бүртгэгдсэн зам тээврийн осол

Монгол Улсын хэмжээнд 2017 онд 36591 зам тээврийн осол бүртгэгдсэний 32662 буюу 89.3 хувь нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол орон нутагт 10.7 хувь буюу 3929 осол бүртгэгдсэн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн ослын хэмжээг 2016 онтой харьцуулахад 10121 осол буюу 21.7 хувиар буурчээ. Орон нутгийн хувьд Орхон аймагт 937, Дархан-Уул аймагт 423, Төв аймагт 478, Дорноговь аймагт 222 осол бүртгэгдсэн бөгөөд бусад аймгуудаас хамгийн өндөр хэмжээнд байгаа юм. Харин дээрхийн эсрэгээр Баян-Өлгий аймагт 14, Булган аймагт 28, Баянхонгор аймагт 32, Говь-Алтай аймагт 42 удаагийн осол бүртгэгдсэн байна.

Зураг 38. Бүртгэгдсэн зам тээврийн осол, аймгаар /2017/



Бүртгэгдсэн зам тээврийн ослыг, ослын хэлбэрээр нь авч үзвэл, улсын хэмжээнд 32214 буюу 88.1 хувь нь мөргөлдөх, 2523 буюу 6.9 хувь нь явган хүн дайрах, 850 буюу 2.3 хувь нь онхолдох хэлбэртэй байна.

Хүснэгт 20. Бүртгэгдсэн зам тээврийн осол, ослын хэлбэрээр

Хэлбэр	Улсын хэмжээнд		Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
Бүгд	36 591	100.0	32 662	100.0	3 929	100.0
Мөргөлдөх	32 214	88.0	29 719	91.0	2 495	63.5
Явган хүн дайрах	2 523	6.9	2 189	6.7	334	8.5
Үл хөдлөх зүйл мөргөх	670	1.8	479	1.5	191	4.9
Онхолдох	850	2.3	133	0.4	717	18.2
Мал, амьтан дайрах	155	0.4	28	0.1	127	3.2
Зорчигч унагах	34	0.1	14	-	20	0.5
Дугуйтай хүн мөргөх	85	0.2	77	0.2	8	0.2
Бусад	60	0.2	23	0.1	37	0.9


5.3 Зам тээврийн ослын ангилал

Бүртгэгдсэн зам тээврийн ослыг эд материалын хохиролтой зам тээврийн осол, хүн гэмтсэн зам тээврийн осол гэж ангилан бүртгэлд авч байна.

Эд материалын хохиролтой зам тээврийн осол: зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг авч үзэж байна.

Хүн гэмтсэн осол: зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох явдлыг авч үзэж байна.

Улсын хэмжээнд 36591 зам тээврийн осол бүртгэн шалгасны 88.8 хувь нь эд материалын хохиролтой осол байхад 11.2 хувь нь хүн гэмтсэн /хүний амь нас, эрүүл мэнд хохирсон/ зэм тээврийн осол байна.



5.4 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг

Монгол улсын хэмжээнд Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1525 бүртгэгдэж нийт гэмт хэргийн 4.7 хувийг эзэлсэн нь бөгөөд өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд 14.5 хувь, нийслэлд 28.5 хувиар буурч, харин орон нутагт 0.1 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн 872 буюу 57.2 хувь нь орон нутагт, 652 буюу 42.8 хувь нь Нийслэлд бүртгэгдсэн байна.


Хүснэгт 21. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг

Д/д	Он	Бүртгэгдсэн зам тээврийн осол		Үүнээс Гэмт хэрэг	
		Улс	Нийслэл	Улс	Нийслэл
1	2016	46 712	41 375	1782	912
2	2017	36 591	32 662	1525	652

5.5 Гэмт хэрэгт холбогдогчийн нас хүйс, боловсрол, нийгмийн байдал

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт 1273 хүн холбогджээ. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн хүйсийн харьцаанаас эрэгтэй жолооч 86.1 хувийг, эмэгтэй жолооч харьцангуй бага 13.9 хувийг эзэлж байна. Мөн насны ангиллаар нь авч үзвэл 18-34 насны залуу хүмүүс 58.7 хувийг эзэлж байна.

Зураг 39. Гэмт хэрэгт холбогдогчид, насны ангиллаар



Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нийгмийн байдлыг авч үзвэл, эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд 48.7 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд 17.4 хувь, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч иргэд 11.8 хувь, төрийн албан хаагч 7.1, малчин иргэд 8.5 хувь, бусад иргэд /оюутан, сурагч/ 6.5 хувийг тус тус эзэлж байна.

Гэмт хэрэгт холбогдсон иргэдийг боловсролын хувьд авч үзвэл, 48.2 хувь нь бүрэн дунд боловсролтой, 24.6 хувь нь дээд боловсролтой байна. Мөн түүнчлэн хэрэгт холбогдсон иргэдийн 1.0 хувь нь урьд нь ял шийтгэл хүлээж байсан тоон үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 21. Гэмт хэрэгт холбогдогчид, боловсролын түвшингээр

Боловсрол	Эзэн, холбогдогчийн тоо	Эзлэх хувь
Бүрэн дунд	614	48.2
Дээд	313	24.6
Бага	81	6.4
Тусгай дунд боловсрол	60	4.7
Боловсролгүй	21	1.6
Бүрэн бус дунд	183	14.4
Техникийн болон мэргэжлийн	1	0.1

5.6 Зам тээврийн ослын улмаас нас барсан гэмтсэн хүн, учирсан хохирол

Зам тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирохоос гадна, эд материалын хохирол учирдаг ба хохиролгүй зам тээврийн осол гэж байхгүй юм. Зам тээврийн ослын улмаас 2017 онд нийт 5219 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирч, үүнээс 507 хүн амь насаа алдсан байна.

5.6.1 Нас барсан хүн

Монгол Улсад нас барсан хүний тоон үзүүлэлтийг зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, гэмт хэргийн улмаас нас барсан хүн гэж ангилан авч үздэг.

Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн гэж газар дээрээ болон хэрэг бүрдэлт, мөрдөн байцаалтын шатанд нас барсан хүн буюу бодит нас баралтын тоон үзүүлэлт бол гэмт хэргийн улмаас нас барсан хүн гэж цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас боловсруулан гаргасан үзүүлэлт буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /ЭХХШТХ/-ийн холбогдох заалтаар хэрэгсэхгүй болгосон хэрэг, хохирлыг хасаж тооцсон тоон үзүүлэлтийг авч үзсэн.

Өнгөрөгч онд улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас 1129 хүн нас барсны 392 хүн буюу 34.3 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон гэмт хэргийн тохиолдол 438 бүртгэгдэж, 507 хүний амь нас хохирсон байна. Нийт амь насаа алдсан хүний 77.9 хувь нь орон нутгийн замд нас баржээ. Амь насаа алдсан хүмүүсийн 92.6 хувь нь 24 цагийн дотор, 7.1 хувь нь 30 хоногт, 0.3 хувь нь 30-аас дээш хоногт нас барсан байна.

Зураг 40. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоо



Зам тээврийн ослын улмаас нас барсан 507 хүний тоон үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд дээрх үзүүлэлт 5.8 хувиар өсөж, нийслэлийн хэмжээнд 11.8 хувийн бууралттай байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 392 хүн нас барсан нь урьд оны үзүүлэлттэй харьцуулахад нас баралт 1.8 хувиар буурсан. Гэмт хэргийн улмаас нас барсан хүний 318 буюу 81.1 хувь нь орон нутагт, 74 буюу 18.9 хувь нь нийслэлд байна.

Зам тээврийн ослын улмаас нас барсан 507 хүний 39.4 хувь нь 35-54 насны хүмүүс байхад, гэмтсэн 4712 хүний 34.1 хувийг 18-34 насны хүмүүс эзэлсэн байна.

5.6.2 Гэмтсэн хүн


Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн – зам тээврийн осолд өртөж их бага, тодорхой хэмжээгээр гэмтэл, бэртэл авсан /зөөлөн эдийн гэмтэл, шарх авсан, шалбарсан, зулгарсан

гэх мэт/ бүх гэмтлийг багтаасан тоон үзүүлэлт юм.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн – зам тээврийн ослын улмаас биед авсан гэмтлийн зэрэг нь шүүх эмнэлгийн магадалгаагаар хүндэвтэр, хүнд зэрэг тогтоогдон эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн улмаас гэмтсэн хүний тоон үзүүлэлт юм.

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 4712 хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл, бэртэл авсан нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 12.3 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 1135 хүн гэмтсэн нь 9.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 41. Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний тоо



5.6.3 Зам тээврийн осолд өртсөн хүний нас, хүйсийн байдал

Зам тээврийн улмаас улсын хэмжээнд амь нас, эрүүл мэндээрээ хохирсон 5219 хүнийг насны байдлаар нь авч үзвэл:

Зураг 42. Зам тээврийн осолд өртсөн хүн, насны бүлгээр



Хохирогчдын хүйсийн харьцааг авч үзвэл нийт осолд өртсөн хүний 2953 буюу 56.6 хувь нь эрэгтэй, 2266 буюу 43.4 хувь нь эмэгтэй байна. Мөн амь насаа алдсан хүний 72.4 хувь, гэмтэгсдийн 54.9 хувийг эрэгтэй хүмүүс эзэлжээ. Нас хүйсийн үзүүлэлтээс дүгнэхэд: 18-45 насны эрэгтэй, хөдөлмөрийн насны хүмүүс замын хөдөлгөөнд зөв оролцоогүй, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, хэн нэгэн буруутай этгээдээс болж амь нас, эрүүл мэндээрээ хохирсон байна.

5.7 Зам тээврийн ослын шалтгаан

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 36591 зам тээврийн ослын 35679 буюу 97.5 хувь нь жолоочийн буруугаас, 868 буюу 2.4 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 44

буюу 0.1 хувь нь замын нөхцөлөөс гэж бүртгэгджээ.

Хүснэгт 22. Зам тээврийн ослын шалтгаан, хот, хөдөөгөөр

Шалтгаан	Улс	%	Улсын дүнд эзлэх хувь			
			Хот	%	Орон нутаг	%
Жолоочийн буруутай үйлдэл	35 679	97.5	31 868	89.3	3 811	10.7
Явган зорчигчийн буруутай үйлдэл	868	2.4	768	88.5	100	11.5
Замын нөхцөл	44	0.1	26	59.1	18	40.9
Нийт дүн	36 951	100.0	32 662	89.3	3 929	10.7

Бүртгэгдсэн зам тээврийн ослын 97.5 хувь нь жолоочийн буруутай үйлдэл буюу жолоочийн хууль, дүрэм зөрчсөн, сахилга хариуцлагагүй үйлдэлтэй холбоотой байна. Зам тээврийн ослын шалтгааныг өнгөрсөн онд бүртгэгдсэн ослын шалтгаантай харьцуулан үзвэл жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол 4.4 хувиар өсөж, явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан осол 24.4 хувь, замын нөхцөлөөс шалтгаалсан осол 22.4 хувиар буурсан байна.

5.7.1 Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол

Жолоочийн буруутай үйлдлээс гарсан ослыг харахад согтуугаар үйлдэгдсэн осол 23.5 хувиар буурсан байхад, явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос үүдэлтэй осол 13.7 хувиар өссөн байна.

Жолоочийн буруутай ослын шалтгаанаас дурдвал хажуу хоорондын зай тохируулаагүйгээс 15869 буюу 43.4 хувь, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн 5592 буюу 15.3 хувь, эгнээ байр буруу эзэлсэн 5421 буюу 14.8 хувь, ухрах үйлдэл буруу хийсэн 2985 буюу 8.2 хувийг эзэлсэн байна.

Зураг 43. Жолоочийн буруутай үйлдлээс гарсан зам тээврийн осол, шалтгаанаар



2017 онд согтууруулах ундааны зүйлс хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос гарсан осол өмнөх оноос 3.8 хувиар буурсан хэдий ч өнгөрсөн онд нийт ослын 1.8 хувийг эзэлж байсан бол энэ онд 2.2 хувийг эзэлж 0.4 пунктээр өссөн байна.

Хурд хэтрүүлсэн ослын шалтгаан нь 2016 оноос 19.9 хувийн өсөлттэй гарсан ба 2017 онд


Нийслэл хотод бүртгэгдсэн байна. Жолоочийн буруугаас үйлдэгдсэн ослын улмаас нийслэлд явган зорчигч, орон нутагт тээврийн хэрэгслээр зорчигч, жолоочийн амь нас, эрүүл мэнд хохирч байна. Хурд хэтрүүлэх нь олонх улс орны зам тээврийн осол гарах үндсэн хүчин зүйл болдог ба энэ нь шинэ, залуу жолооч нартай холбоотой байна. Хурдыг 1 км/цаг-аар бууруулахад зам тээврийн осол 4-5 хувь буурдаг гэж олон улсад үздэг байна.

5.7.2 Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 2017 онд улсын хэмжээнд 868 буюу нийт бүртгэгдсэн осолд 2.4 хувийг эзэлсэн байна. Явган зорчигчдын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг хүсдэггүй, тэдэнд оногдуулах хариуцлага хэрэгжихгүй байгаагаас явган зорчигч амь насаа алдах, гэмтэл бэртэл авч хохирч байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол өнгөрсөн оноос буурсан хэдий ч явган зорчигч осолд өртөх, хохирох үзүүлэлт байсаар байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 868 бүртгэгдсэний 768 буюу 88.5 хувь нь Нийслэлд бүртгэгдсэн байна. Явган зорчигчийн буруутай үйлдэл дотроо явган зорчигч замын хөдөлгөөнд согтуугаар оролцож өртсөн тохиолдол 32.7 хувийг эзэлсэн байна.

Зураг 44. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол



Улсын хэмжээнд 2017 оны байдлаар 284 ослын тохиолдолд явган зорчигч согтуугаар /согтуу зам дээр хэвтэх, унтах, автомашин зогсоох гэж байгаад ойчих, зорчих хэсэг дээр бие засах, гарцгүй газраар автомашины урдуур гүйх, унах/ замын хөдөлгөөнд оролцож амь нас эрүүл мэндээрээ хохирч байна. Мөн зорчигчийн буруутай үйлдэл дотроо сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүй замын хөдөлгөөнд оролцуулснаас бүртгэгдсэн осол улсын хэмжээнд 63, Нийслэлд 42 бүртгэгдсэн байна.

Явган зорчигчдын замын хөдөлгөөнд оролцож байгаад хяналт тавих, тэдний хөдөлгөөнд оролцох мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, жолооч нарт замын хөдөлгөөний дүрмээ биелүүлэх дадал, чадварыг бий болгох сэтгэл зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгаа явуулахад анхаарал хандуулах зайлшгүй шаардлага байгаа нь 2017 онд 143 явган зорчигч амь насаа алдсан тоон үзүүлэлтээс харагдана.

5.8 Зам тээврийн ослын хэлбэр

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 32214 буюу 88.0 хувь нь мөргөлдөх,

2523 буюу 6.9 хувь нь явган зорчигч мөргөх, 850 буюу 2.3 хувь нь онхолдох, 670 буюу 1.8 хувь нь үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн, 34 осол зорчигч унагах, 85 унадаг дугуйтай хүн мөргөх, 155 осол мал, амьтан дайрах, 60 осол бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 23. Улсын хэмжээнд үйлдэгдсэн зам тээврийн ослын хэлбэр

	Улс	%	Хот	%	Орон нутагт	%
Мөргөлдөх	32 214	88.1	29 719	91.0	2 495	63.6
Явган хүн дайрах	2 523	6.9	2189	6.7	334	8.5
Үл хөдлөх зүйл мөргөх	670	1.8	479	1.5	191	4.9
Онхолдох	850	2.3	133	0.4	717	18.2
Мал, амьтан дайрах	155	0.4	28	0.1	127	3.2
Зорчигч унагах	34	0.1	14	-	20	0.5
Дугуйтай хүн мөргөх	85	0.2	77	0.2	8	0.2
Бусад	60	0.2	23	0.1	37	0.9

Зам тээврийн осол гарсан хэлбэрээс авч үзвэл: Улсын хэмжээнд явган зорчигч мөргөх хэлбэрээр 2189 буюу 86.8 хувь нь Нийслэлд, улсын хэмжээнд онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн ослын 717 буюу 84.4 хувь нь орон нутагт бүртгэгджээ.

Зам тээврийн ослын гарч буй хэлбэрийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад онхолдох хэлбэрээр гарсан осол 3.4 хувь, үл хөдлөх зүйл мөргөх хэлбэрээр гарсан осол 13.1 хувь, зорчигч унагасан хэлбэрээр гарсан осол 35.8 хувь, явган зорчигч мөргөх хэлбэрээр 7.2 хувь, дугуйтай хүн дайрах хэлбэрээр гарсан осол 37.0 хувь, мал амьтан дайрах хэлбэр 20.5 хувиар буурсан байна.


Улсын хэмжээнд тээврийн хэрэгсэл онхолдсоноос 189 хүний амь нас хохирсны 176 буюу 93.1 хувийг орон нутгийн замд гарсан осол эзэлсэн байна. Орон нутагт онхолдох хэлбэрээр гарч буй зам тээврийн осол нь бүрэн бус мотоциклоор хөдөлгөөнд оролцох, согтуугаар жолоодох, хурд хэтрүүлэх зэрэг тохиолдол байна.

5.9 Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Улсын хэмжээнд 2017 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 1018, үүнээс хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 241 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Зам тээврийн осолд улсын хэмжээнд нийтдээ 4712 хүн гэмтэж, 507 хүн нас барснаас, 1058 хүүхэд бэртэж, гэмтэн, 55 хүүхэд амь насаа алдсан байна. Гэмтсэн 1058 хүүхдээс 186 нь хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ. Улсын хэмжээний үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад нас барсан хүүхэд 10.0 хувиар, гэмтсэн хүүхдийн тоо 17.0 хувиар буурчээ. Гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн 83.6 хувь буюу 46 хүүхэд орон нутгийн замд амь насаа алдсан байна.

2017 онд зам тээврийн осолд өртсөн хүүхдийн 40.2 хувийг 0-6 хүртэл насны хүүхэд, 43.2 хувийг 7-14 насны хүүхэд, 16.6 хувийг 15-17 насны хүүхэд эзэлсэн байна. Нийт зам тээврийн осолд өртсөн хүүхдийг хүйсийн байдлаас үзэхэд 60.7 хувь нь эрэгтэй, 39.3 хувь нь эмэгтэй хүүхэд байгаа нь эрэгтэй хүүхдүүд зам тээврийн осолд илүү өртөж байгааг харуулж байна.

Зураг 45. Улсын хэмжээнд осолд өртсөн хүүхдийн тоо, насны бүлгээр



Хүн бүр замын хөдөлгөөнд явганаар оролцдог учир хүүхдийг багаас нь замын хөдөлгөөнд ялангуяа явганаар замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, хандлага, дадлыг эзэмшүүлэхэд илүү анхаарал хандуулах шаардлагатай байна.

Хүснэгт 24. Хүүхэд өртсөн зам тээврийн осол, нас барсан, гэмтсэн хүүхэд

Он	Нийт	Орон нутагт	Улаанбаатар хотод	
Нас барсан	2005	54	27	27
	2006	36	28	8
	2007	32	23	9
	2008	40	27	13
	2009	36	27	9
	2010	28	18	10
	2011	40	26	14
	2013	37	27	10
	2014	48	38	10
	2015	54	42	12
	2016	50	45	5
2017	55	46	9	
Гэмтсэн	2005	646	121	525
	2006	851	53	798
	2007	795	30	165
	2008	602	65	537
	2009	538	54	484
	2010	656	45	611
	2011	935	59	876
	2013	1231	81	1150
	2014	1164	95	1069
	2015	1089	91	998
	2016	1065	95	970
2017	1058	138	920	

Зам тээврийн осолд өртсөн 1113 хүүхдийн 69.4 хувь нь явганаар, 26.2 хувь нь тээврийн хэрэгслээр зорчигч, 4.4 хувь нь унадаг дугуйгаагаар замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөж хохирсон байна.

Товч дүгнэлт

Манай улсын тээврийн салбарт 2017 онд гадаадын болон дотоодын эх үүсвэрээс 142.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, улсын төсвийн хөрөнгөөс 77.2 тэрбум төгрөгийг, тээврийн сүлжээний сайжруулалтад зориулж зарцуулсан байна. Улс орны хөгжлийн салшгүй нэг хэсэг болсон тээврийн салбарт өнгөрөгч онд эдийн засгийн үр ашигтай, томоохон төсөл хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Төв аймагт баригдаж буй олон улсын шинэ нисэх онгоцны буудал, Дорноговь аймгийн Сайншанд суманд хэрэгжиж буй бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төслийг амжилттай урагшлуулж байна. Мөн өргөн уудам нутагтай, хүн ам сийрэг суурьшсан манай улсад чанартай, хүртээмжтэй авто замын сүлжээг бий болгохоор, сүүлийн 6 жилийн хугацаанд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, авто замын бүтээн байгуулалтыг эрчимтэй явуулсанаар, улсын хэмжээнд авто замын сүлжээний нийт урт 2017 оны байдлаар 113.2 мянган километр, үүнээс хатуу хучилттай нь 10.6 мянган километр, хучлагагүй буюу ердийн болон сайжруулсан хөрсөн зам 102.6 мянган километр болжээ.

Авто замын бүтээн байгуулалт, шинэчлэлтийг дагаад сүүлийн жилүүдэд тээврийн хэрэгслийн тоо тогтмол өсөн нэмэгдэж, 2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд 900.1 мянган тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Эдгээр тээврийн хэрэгслээс техникийн улсын үзлэгт 536.4 мянга буюу 59.6 хувь хамрагдсан бөгөөд үзлэгт хамрагдаагүй автомашинууд нь ашиглалтаас гарсан ч улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хасалт хийлгээгүй шалтгаантай байна. Автомашин иргэдийн амьдралд өдөр дутмын хэрэглээ болж тээврийн хэрэгслийн тоог хурдацтайгаар өсөхөд нөлөөлж байгаа нь гаалийн статистик мэдээнээс бэлхэнээ харагдаж байна. Монгол Улсад өнгөрсөнд онд 48 870 суудлын автомашин импортоор оруулж ирсэн нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортод түшиглэсэн экспортын бүтэцтэй манай улсын хувьд тээврийн салбар нь эдийн засагт багагүй байр суурийг сүүлийн жилүүдэд эзлэх боллоо. Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2017 оны урьдчилсан дүнгээр 27.2 их наяд төгрөг болсон ба үүнээс 1.3 их наяд төгрөг буюу 4.8 хувийг эзэлж, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, худалдааны салбарын дараа орж байна. Хэдийгээр тээврийн салбар нь эдийн засгийн хөдөлгөгч хүч биш ч гэсэн, өнхрөх дугуй нь болж өгдгөөрөө чухал ач холбогдолтой юм. Уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн мөн төмөр замын транзит тээвэрлэлтийн ачаа нэмэгдсэнтэй зэрэгцээд Монгол Улсын тээврийн салбарын үндсэн үзүүлэлтэд эерэг нөлөө үзүүлсэн он жилүүд үргэлжилж байна. Манай улс 2017 онд бүх төрлийн тээврээр 54.0 сая тонн ачаа тээвэрлэж, ачаа эргэлт 19162.4 сая тонн километр хүрсэн нь 1990 оноос хойш хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Өнгөрөгч онд зам тээврийн ослын шинжтэй дуудлага 92.3 мянга болж, бүртгэгдсэн зам тээврийн осол 36.6 мянга болж 2016 оноос ослын шинжтэй дуудлага 2.6 хувь, зам тээврийн осол 21.7 хувиар тус тус буурсан байна. Бүртгэгдсэн зам тээврийн ослоос 5219 хүн гэмтэж, нас барсан байна. Нийт зам тээврийн ослын тэргүүлэх 3 шалтгаанд:

- Жолоочийн буруутай үйлдлээс үүдэлтэй зам тээврийн осол
- Уулзвар гарц, нэвтрэх журам зөрчсөн
- Эгнээ байраа буруу эзэлсэнээс үүдсэн ослууд багтаж байна.

Энэ нь жолооч нарын замын хөдөлгөөний соёл дутмаг байгааг харуулж байна. Мөн зам тээврийн ослын улмаас улсын хэмжээнд 5219 хүн гэмтэж, үүнээс 507 хүн нас барсны 1058 нь буюу 20.3 хувийг хүүхэд өртсөн зам тээврийн осол эзэлж байгаа бөгөөд үүнээс 55 хүүхэд буюу 5.2 хувь нь нас барсан байна. Хүүхэд өртсөн зам тээврийн ослын 920 нь буюу 87 хувь нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэгджээ.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН 2017 ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ТЭЭСЭН АЧАА, сая тонн



ТЭЭСЭН ЗОРЧИГЧ, сая хүн



ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИН, улсаар



ТЭЭВРИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг

